

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +26
Шөнө +13

ДЭЛХИЙ

ХАЛЦЛАГА, БОСЛОГОД ӨРТӨЖ, ОНЦ БАЙДАЛ ЗАРЛАСАН ДОЛОО ХОНОГ

VI нүүрт

ШУУРХАЙ МЭДЭЭ

ИРГЭД УХАМСАРГҮЙ ҮЙЛДЛЭЭСЭЭ БОЛЖ УСАНД ОСОЛДОХ НЬ ИХЭССЭН

VII нүүрт

ЖАН КЛОД ЮНКЕР: Ц.ЭЛБЭГДОРЖ БОЛ МОНГОЛООС ТӨРСӨН ДЭЛХИЙН УДИРДАГЧ

Дугаарын **60** мөр

Риогийн тэнгэрт төрийн далбаагаа намирахыг харах л үлдлээ

Э.ТУУЛ

Монгол Улс 2016 онд онцлох олон үйл явдлын эзэн байлаа. Сонгуулиа ч зохион байгуулж, наадмаа ч сайхан тэмдэглэж, одоо хүртэл наадамласаар л явна. Төрийн их баяр наадамтай залгасан АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг ч чамбай сайн зохион байгуулж, олон орны төрийн тэргүүнүүдээс онц үнэлгээ авлаа. Их ч ажил амжууллаа. Одоо бидэнд нэг том ажил үлдсэн нь РИО-2016 олимпын наадам. Хүн төрөлхтөний спортын эв нэгдлийн хамгийн том баяр "Рио-2016" зуны 31 дүгээр олимпын наадам Бразил улсын Рио де Жанейро хотноо эхлэхэд тун цөөхөн хоног үлдлээ. Бүр тодруулбал, зуны 31 дүгээр олимпын их наадам Рио де Жанейро хотноо 2016 оны наймдугаар сарын 5-21-нд болно.

Манай улс 1992 оны Барселонагийн зуны олимпын наадмаас хойш 2008 оны Бээжин, 2012 оны Лондонгийн зуны олимпын наадамд спортын долоон төрөлд 29 эрх авч оролцож байсан бол эдүгээ "Рио-2016" зуны олимпын наадамд анх удаа спортын есөн төрөлд 49 эрх авч, түүхэндээ Монгол Улсаас хамгийн олон тамирчин оролцохоор болоод байгаа юм.

Үргэлжлэл нь III нүүрт



Гэрэл зургийг МОНГОЛЫН ГЭРЭЛ ЗУРАГЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО Г.АРГУУЖИН

Дэлгэрэнгүйг III нүүрнээс

АЙЛЧЛАЛ

ПАК ГЫН ХЭ: Монгол Улсын эдийн засаг болон ардчилал улам илүү хөгжсөнийг харлаа



Ж.ОТГОН

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ өчигдөр, өнөөдөр хоёр өдөр Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байна. Хатагтай Пак Гын Хэ АСЕМ-ийн дээд түвшний 11 дүгээр уулзалтад

оролцсон. Тэрбээр Ази болон Европын Сангийн сайд нарын удаан хугацаанд тасалдсан уулзалтыг ирэх онд улсдаа зохион байгуулах саналыг дэвшүүлж, нээлттэй бөгөөд чөлөөт худалдааг хөгжүүлэн дэмжихийн тулд хүчээ нэгтгэхийг хоёр тивийн удирдагчдад уриалсан юм.

Үргэлжлэл нь II нүүрт

САЙД ЯРЬЖ БАЙНА



Э.МӨНХ

Ази-Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт Улаанбаатар хотноо болж, амжилттай өндөрлөв. Тэгвэл АСЕМ-ын бэлтгэл ажилд ЗТЯ-наас хэрхэн оролцсон болон энэ хүрээнд ямар ажлууд хийгдсэн талаар Зам тээврийн сайд М.Зоригттой ярилцлаа.

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ОНЦЛОХ МЭДЭЭ

Хэлж байснаа санадаг л байгаа даа

УИХ-ын сонгуульд ялалт байгуулсан МАН-ынхан Засгийн газраа хэрхэн бүрдүүлэх вэ гэдэг нь анхаарал татсан асуудал хэвээр байсаар. Тус намынхан сонгуульд оролцоходоо "Мэргэжлийн Засгийн газар байгуулна" хэмээн мөрийн хөтөлбөртөө тусгасан. Мэргэжлийн гэдэг үгийг энгийнээр ойлговол "давхар дээлгүй", тухайн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан, дадлага туршлагатай, салбарынхаа зөвлөнг ойлгодог нэгнийг томилоно гэж ойлгож болох юм. Түүнчлэн цомхон бүтэцтэй, чадварлаг багтай байна гээд МАН-ын удирдлагууд Засгийн газраа 12 яам, 15 сайдтай байгуулах сураг дууддаг буй. Угтаа бол ялсан намын дарга шууд Ерөнхий сайдын албыг хашиж үүрэг хүлээдэг. Гэвч МАН үнэмлэхүй олонхи гэдгээрээ түрсээр наадмаас өмнө Ерөнхий сайдаараа Ж.Эрдэнэбатыг томилж амжсан. Харин одоо өнөөх хэлээд байгаа "Мэргэжлийн Засгийн газар"-аа байгуулах ажил үлдээд буй. Одоогийн байдлаар олны дунд Шадар сайдад У.Хүрэлсүх өрсөлдөгчгүй томилогдоно гэсэн "бор шувуу" жиргэж байна. Харин Засгийн газрын гал тогоог хариуцагч Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд болохыг хүсэгчид цөөнгүй байгаа гэнэ. Тухайлбал, Ж.Мөнхбат, Ч.Хуралбаатар, УИХ-ын гишүүн асан Т.Ганди гэх мэтээр бялуу хүртэгсдийн цуваа үргэлжилж байгаа сурагтай. Харин Хууль зүйн яамыг Ц.Нямдоржтой булаацалдах хүн гарахгүй гэж байсан ч 2009-2010 онд УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллаж байсан, УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ өрсөлдөхөөр гарч ирсэн гэнэ. Мөн Д.Зоригт Эрчим хүчний сайдад зүтгэх бол Ц.Дашдорж Барилга, хот байгуулалтын сайдад, Гадаад

харилцааны сайдад Д.Цогтбаатар яригдаад эхэлж. Бас Сангийн яаманд Ж.Эрдэнэбат, Ч.Хуралбаатар, Д.Хаянхярваа гэсэн нэрс дууддаг буй бол Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамыг Ё.Отгонбаяр, Батлан хамгаалах яамыг Ж.Энхбаяр авах магадлал нэлээд өндөр хувьтай яваа гэнэ шүү. Мөн хамгийн их анхаарал татаж буй Эрүүл мэндийн яаманд дэд сайд асан Ж.Цолмон, УИХ-ын гишүүн асан Д.Очирбаттай өрсөлдөж байгаа гэх. Хүнс, хөдөө аж ахуйн яамыг одоогоор нийлүүлэх үү, тусад нь байлгах уу гэдэг эцсийн шийдвэр гараагүй ч өмнө нь дэд сайдаар ажиллаж байсан Ж.Саулег томилж сурагтай. Бас нэгтгэсэн яамдад хоёр дэд сайд ажиллуулах тухай ч дууддаг байна. Ерөнхийдөө үндсэн чиг үүргийн гурван яамнаас бусдад нь "давхар дээлгүй" сайд томилогдох ёстой. Тэгж байж, МАН-ынхан амлалтандаа хүрнэ. Гэвч бодит байдалд Засгийн газрын 15 сайдын тал хувь нь "давхар дээлтэй" томилогдохоор дүр зураг харагдаад байна. Тэд өмнө нь дампуурсан төр засгийн давхар дээлийг тайлуулах цуглааныг зохион байгуулж, "Давхар дээлийг тайлтал нь, хэрэв тайлахгүй бол Засгийн газрыг огцортол нь, Засгийн газраа хаацалбал УИХ-ыг тартал нь тэмцэнэ" гэж хэлж байснаа санадаг л байгаа даа. Ямартай ч энэ мэтчилэн МАН-ынхан албан тушаалын бялуугаа хуваагаад эхлэх нь мэдээж. Харин хэн ямар албан тушаалд очиж, бялуунаас зүсэм хүртэх нь тун удахгүй тодорхой болох биз ээ. Дашрамд дурьдахад, Монгол Улсын гурав дахь Ерөнхийлөгч асан Н.Энхбаярын шадар туслах, зөвлөх зэрэг албыг хашиж байсан ойрын хүмүүс нь бялуу хүртэхээр зүтгэж байгаа нь МАН-ынхны дургүйг хүргээд байгаа гэнэ билээ.

М.ЗОРИГТ: АСЕМ-ЫГ ӨӨРИЙН УЛСАД САЙН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХАРИУЦЛАГАТАЙ АЖИЛД ЗТЯ ЧУХАЛ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ ОРОЛЦЛОО

-АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөв. Ингэхэд АСЕМ-ын бэлтгэл ажилд ЗТЯ-наас ямар үүрэгтэйгээр оролцов? -Монгол Улс АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг энэ сарын 14-16-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа. Олон улсын хэмжээнд нэр хүндтэй энэхүү томоохон арга хэмжээг өөрийн улсад сайн зохион байгуулах хариуцлагатай ажилд ЗТЯ чухал үүргийг гүйцэтгэж

оролцлоо. Тодруулбал, Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Дээд түвшний 11 дүгээр уулзалтын бэлтгэл хангах, зохион байгуулах, чиг үүргээр хангах Үндэсний зөвлөлд Зам, тээврийн сайд орж ажилласан бөгөөд Зам, тээвэр, харилцаа холбоо, нисэх буудлын асуудал хариуцсан Ажлын хэсгийн ахлагчаар ажилласан. Ерөнхийдөө Зам тээвэр, харилцаа холбоо, нисэх буудлын асуудал хариуцсан Ажлын хэсгийн зүгээс гурван үндсэн чиглэлийн ажлыг хариуцан гүйцэтгэж ажилласан.

Үргэлжлэл нь IV нүүрт

ХААН Банк			Хугалгаа хөгжлийн банк		
	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2012.00	2030.00	ФУНТ	2566.00	2680.00
ЕВРО	2207.00	2290.00	РУБЛЬ	29.50	34.00
ИЕН	19.78	20.56	ЮАНЬ	300.00	306.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

АЙЛЧЛАЛ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Терроризм, хэт даврүү үзэл, уур амьсгалын өөрчлөлт болон Умард Солонгосын цөмийн аюул заналхийлэл зэрэг бүс нутагт болон олон улсад тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд гол үүрэг гүйцэтгэх тус хоёр тивийн зөвлөлдөх эвсэл байгуулах хэрэгтэй байгааг Ерөнхийлөгч Пак мөн онцлон тэмдэглэсэн юм. Пак Гын Хэ хэлэхдээ “АСЕМ-ын энэ удаагийн Дээд түвшний уулзалт нь бүс нутагт чөлөөт худалдааг хөхнүлэн дэмжиж, эдийн засгийн өсөлт жигд сайжирч, бүтээлч санаачилгыг бий болгоход түлхэц үзүүлнэ гэж найдаж байна. Илүү үр бүтээлтэй төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэхийн тулд АСЕМ-ын сангийн сайд нарын уулзалтыг ирэх онд Өмнөд Солонгост зохион байгуулахыг би санал болгож байна” гэлээ. АСЕМ-ын гишүүн улсуудын Сангийн сайд нарын уулзалтыг сүүлд 2003 онд Хятад улсад зохион байгуулсан бөгөөд үүний дараа дахин зохион байгуулахаар тохиролцсон боловч Мьянмарын хүний эрхийн асуудалтай холбоотойгоор АСЕМ-ын гишүүд санал зөрөлдөөнтэй байсны улмаас энэ уулзалтыг дахиж зохион байгуулаагүй ажээ. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар хийж буй түүний албан ёсны айлчлал нь өчигдөр өглөө эхэлсэн юм. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ-г Эзэн Чингисийн нэрэмжит талбайд угтан авч, Төрийн хүндэт харуул жагсав. Угтах ёслолын дараа эрхэм зочин Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүллээ. БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ-гийн албан ёсны айлчлал хоёр орны “Иж бүрэн түншлэл”-ийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, дээд, өндөр түвшний харилцан айлчлалын давтамжийг хадгалах, ялангуяа эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, иргэд харилцан солилцоог нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Айлчлалын

ПАК ГЫН ХЭ: МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ БОЛОН АРДЧИЛАЛ УЛАМ ИЛҮҮ ХӨГЖСӨНИЙГ ХАРЛАА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

үеэр БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ УИХ-ын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд нартай уулзана. Мөн Ерөнхийлөгч Пак Гын Хэ Монгол-Солонгосын бизнес форумд оролцож, Монголд амьдарч ажиллаж буй солонгос иргэдийн төлөөлөлтэй уулзахаар төлөвлөн.

Ганцаарчилсан уулзалт хийлээ

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байгаа БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ нар ганцаарчилсан уулзалт хийлээ. Уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Ерөнхийлөгч Пак Гын Хэ-тэй хоёрхон сарын дараа дахин уулзсандаа баяртай байгаагаа илэрхийлж, Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтад оролцож, арга хэмжээний ач холбогдлыг нэмэгдүүлсэн явдалд талархал илэрхийлсэн юм. БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ Монгол Улс олон улсын дээд түвшний уулзалтыг эх орондоо амжилттай зохион байгуулсанд талархал илэрхийлж, хоёр орны хооронд дээд, өндөр түвшний айлчлал, яриа хэлэлцээ ойр ойрхон хэрэгжиж байгаа нь БНСУ, Монгол Улсын харилцааг эрчимжүүлэх, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтойг дурьдав. Мөн хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх талаар санал солилцон ярилцлаа.

“Монгол Улс, БНСУ-ын харилцаа улам шинэ шатанд гарна”

Ганцаарчилсан уулзалтын дараа Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ нар Төрийн ордны “Жанжин Сүхбаатар” танхимдалбан ёсны хэлэлцээний дараа хоёр улсын Ерөнхийлөгч хэвлэл мэдээллийнхэнд хандаж мэдээлэл хийв. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ энэ өдрүүдэд манай улсад айлчилж байна. Эрхэмсэг ерөнхийлөгч АСЕМ-ын Дээд түвшний уулзалтад амжилттай оролцсон. АСЕМ-ын уулзалтыг зохион байгуулахад БНСУ-ын Засгийн газар, Ерөнхийлөгчийн зүгээс анхаарал хандуулж хамтарч ажилласанд баярлаж байна. Хоёр сарын өмнө би БНСУ-д айлчлал хийсэн. Тэр үеэр ярилцсан олон асуудал өнөөдөр ерөнхийлөгчийн айлчлалын үеэр ажил хэрэг болж, санал нэгдэж гарын үсэг зурж байгаад баяртай байна. Манай хоёр орны харилцаа нэгдмэл үнэт зүйлсэд суурилсан иргэдийн харилцаанд тулгуурласнаараа онцлогтой. Манай хоёр орны харилцаанд Монгол-Солонгос хоёр орны Засгийн газрын хамтарсан

хороо маш их үүрэг гүйцэтгэсэн гэдгийг хэллээ. Эрхэмсэг Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр “Ухаалаг боловсрол” төслийг эхлүүлж байгаад баяртай байна. Төсөв хүндэтгэлийн үед ЕБС-ийн сургалтын чанарыг сайжруулах, мэдээллийн технологид суурилсан сургалтын чанарыг дээшлүүлэхэд энэхүү төсөл маш чухал үүрэг гүйцэтгэх юм. Мөн эрхэмсэг Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр мэдээллийн технологийн хамтарсан коллеж байгуулах, цаашид инженер техникийн ажилтнуудыг үе шаттайгаар Солонгос улсад бэлтгэхэд хамтарч ажиллаж гэж ярилцлаа. Монгол бол байгалийн их өвтэй орон. Улаанбаатар хотод Байгалийн түүхийн музейн шинэ барилгын асуудал энэхүү айлчлалын үеэр шийдэгдэж байгаа. Энэ бол бас нэг чухал ажил. Нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төслийн хоёр дахь шат айлчлалын хүрээнд гарын үсэг зурж эхэлж байгаад баяртай байна. Сэргээгдэх эрчим хүчний чиглэлд мөн бүхэл бүтэн цогцолбор бий болгоход судалгаа хийх тал дээр тохиролцлоо. Монголд оношилгооны шинэ төв байгуулах ажил эхэлж байгаа. Энэ тал дээр Солонгосын талаас дэмжлэг үзүүлж ажиллаж байгаад маш их баяртай байна. Түүнчлэн агаарын салбарт хамтарч ажиллах чиглэлд тогтож ярилцлаа. Мөн ирээдүй үеийн солилцоонд анхаарсан хөтөлбөр хэрэгжүүлэхээр ярьсан. Мөн хоёр орон Солонгосын хойгийг цөмийн зэвсэгт ангид байлгаж, энэ бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах чиглэлд хамтарч асуудлыг хөндөж ярилцлаа. НҮБ болон бүс нутгийн байгууллагууд, олон улсын байгууллагын хүрээнд бие биеэ дэмжиж ажиллахаар тохиролцсон нь чухал байлаа. Хатагтай Ерөнхийлөгчийн Монголд хийж буй айлчлал ганзага дүүрэн айлчлал байв. Энэ айлчлал хоёр орны хамтын ажиллагааг улам урагшлуулан бэхжүүлэхэд улам их хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна. Монголд дахин айлчлахыг хүсэн ерөөе” гэв. Харин БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ “Юуны түрүүнд манай төлөөлөгчдийг халуун дотноор хүлээж авсанд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж танд болон Монголын ард түмэнд чин сэтгэлийн талархлаа илэрхийлэе. Энэ жил АСЕМ-ын 20 жилийн уулзалтыг амжилттай зохион байгуулсанд баяр хүргэе. Өнгөрсөн онд Солонгос-Монгол хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 25 жилийн ой тохиосон. Одоо бид шинэ 25 жилийн ойг угтах гаран дээр зогсож байна. Өнгөрсөн тавдугаар сард эрхэм Ерөнхийлөгч та манай улсад айлчилснаас хойш ердөө хоёр сарын дараа миний бие Монгол Улсад айлчилж байгаа нь хоёр орны харилцааны хөгжлийн талаархи бидний хүсэл эрмэлзлийг тодорхой харуулж байна гэж бодож байна. Өнөөдрийн албан

ёсны хэлэлцээ олон салбарт хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх арга замын талаар үр дүнтэй ажиллах бололцоог олгосон. Сүүлийн үед хоёр орны өндөр дээд түвшний харилцан айлчлал урьд урьднхаас илүү идэвхжсэн бөгөөд миний бие энэхүү боломжийг үр дүнтэй ашиглан, хоёр орны аюулгүй байдлын салбарыг бэхжүүлэхийг хүсч байна. Манай хоёр орон Солонгосын хойг, Зүүн хойд Азийн энх тайван, тогтвортой байдлыг хангах тал дээр стратегийн хувьд ижил байр суурийг хадгалж байдаг. Өнөөдрийн албан ёсны хэлэлцээний үеэр бид Хойд Солонгост цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх талаар хатуу байр суурин дээрээ үндэслэн Солонгосын хойг болон бүс нутгийн тогтвортой байдлын төлөө хамтран хүчин чармайлт гаргахаар тохиролцсон билээ. Миний бие Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой өнгөрсөн хугацаанд цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх, хоёр Солонгосын нэгдлийг дэмжиж буйгаа илэрхийлсэн явдалд гүнээ талархаж байгаагаа илэрхийлсэн. Цаашид ч миний бие бүс нутгийн тогтвортой байдлыг хамтран ажиллахыг хүсч байна. Миний бие сүүлийн үед үзүүсэд буй олон улсын эдийн засгийн хүнд нөхцөл байдал дүнд чөлөөт худалдааг хумих биш өргөтгөхөд анхаарах хэрэгтэй хэмээн бодож байна. Энэ талаас авч үзвэл энэ удаад Монгол Улсад хийж буй айлчлалын үеэр Монгол Улс, БНСУ-ын хооронд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулах тухай зорилго бүхий хамтарсан судалгааг эхлүүлэх болсонд туйлын баяртай байна. Энэхүү хүчин чармайлт нь алс хэтдээ манай хоёр орны гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх алхам болно гэдэгт найдаж байна. Энэ удаагийн албан ёсны хэлэлцээгээр дамжуулан хоёр орны төрийн тэргүүн нар цахилгаан станц, шинэ болон сэргээгдэх эрчим хүч зэрэг байгаль орчинд ээлтэй эрчим хүчний хөтөн байгуулах зэргээр эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг үр дүнтэй болгоход хүчин чармайлт гаргахаар тохиролцлоо. Мөн бид эрдэс баялаг, эрчим хүч зэрэг уламжлалт салбараас гадна хамтын ажиллагаагаа солонгоруулах арга замын талаар санал солилцлоо. Үүний нэг тод жишээ нь өргөн уудам газар нутаг бүхий Монгол Улсын онцгой тохирсон алсын зайн эмчилгээ оношилгооны хүртэц нь монголын ард түмний эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахад тус дөхөм болно хэмээн үзэж байна. Энэ удаагийн санамж бичиг нь энэхүү салбарт хоёр орны хамтын ажиллагаанд ахиц болно гэдэгт найдаж байна. Хөгжлийн хамтын ажиллагааны талаас авч үзвэл Монгол Улс манай чухал түнш орон. Монголын талаас санал тавьсан хэд хэдэн төслийг судалж байгаа бөгөөд Солонгосын хөгжлийн туршлага

Монголын хөгжлийн стратегид хувь нэмэр оруулах чиглэлээр хөгжлийн хамтын ажиллагааны тал дээр цаашид анхаарах болно. Хоёр улсын иргэд хоорондын харилцаа өргөжиж байгаа нь хоёр улсын харилцааны хөгжлийн нэгэн чухал баялаг юм. Хоёр орны төрийн тэргүүн нар цаашид хоёр орны иргэдийн харилцааг улам илүү өргөжүүлэх үүднээс хүчин чармайлт гаргахаар болсон бөгөөд ялангуяа харилцан зорчих асуудлыг тогтворжуулах, оршин суух баталгааг хангах зэрэгт холбогдох арга хэмжээг авч ажиллахаар болсон. Агаарын тээврийн хүчин

...БНСУ-д тодорхой үе шаттайгаар бэлтгэх зэрэг төслүүдийг хэрэгжүүлэхээр тохирлоо. Энэ мэт хоёр тал хамтын ажиллагааны 20 гаруй баримт бичигт гарын үсэг зурсан юм. Тухайлбалбал, БНСУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагааны сан /EDCF/-гийн 19.6 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр “Ухаалаг боловсрол” төслийг хэрэгжүүлэх зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурлаа...

цадлыг нэмэгдүүлэх асуудлаар талууд нэгдмэл байр суурин дээрээ үргэлжлүүлэн ажиллахаар болсон. Миний бие иргэд хоорондын харилцаа, ялангуяа хойч үеийн харилцаа чухал хэмээн үзэж байгаа бөгөөд иймээс хоёр орны соёлын харилцааг нэмэгдүүлэх үүднээс тасралтгүй бэхжүүлэхийг чухал хэмээн үзэж болно. Энэ удаа соёлын харилцааны талаар санамж бичиг байгуулснаар бүтцийн хувьд үндэс суурь нь тавигдсан учраас соёлын харилцаа, соёлын аж үйлдвэрийн харилцаа бэхжин үр дүнд хүрнэ хэмээн найдаж байна. Эрхэм зочид оо, өнөөдрийн албан ёсны хэлэлцээгээр дамжуулан манай хоёр улсын түвшинд төдийгүй Зүүн Хойд Азийн бүс нутгийн хөгжил цэцэглэлтэд мөн адил хувь нэмэр оруулах чухал түнш гэдгийг дахин нотлох завшаан тохиолоо. Энэ удаагийн айлчлал маань Монгол Улсын агуулж буй ноёд бололцоо, хоёр орны харилцааны

гэрэлт ирээдүйг тольдон харах бололцоо олгосон ач холбогдолтой айлчлал болж байна. Өнөөдрийн албан хэлэлцээ цаашдын хамтын ажиллагааны хоёр орны шинэ 25 жилийн түүхэн хуудсыг нээх чухал эхлэл болж байна хэмээн найдаж байна” гэлээ. Ийнхүү хоёр тал албан ёсны хэлэлцээгээр харилцан байгуулах баримт бичгүүдээ тохиролцож, худалдаа, эдийн засаг, дэд бүтэц зэрэг салбарын асуудлаар харилцан ярилцлаа.

БНСУ-ын буцалтгүй тусламжаар Байгалийн түүхийн музей барина

Айлчлалын хүрээнд БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотноо Байгалийн түүхийн музейн барилга барих, Мэдээлэл технологийн хамтарсан коллеж байгуулах, цаашид инженер техникийн мэргэжилтнүүдийг БНСУ-д тодорхой үе шаттайгаар бэлтгэх зэрэг төслүүдийг хэрэгжүүлэхээр тохирлоо. Энэ мэт хоёр тал хамтын ажиллагааны 20 гаруй баримт бичигт гарын үсэг зурсан юм. Тухайлбалбал, БНСУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагааны сан /EDCF/-гийн 19.6 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр “Ухаалаг боловсрол” төслийг хэрэгжүүлэх зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Төслийн хүрээнд Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулиудад smart анги байгуулах, сургалтын арга зүйг сайжруулах, орчин үеийн smart тоног төхөөрөмж дээр хичээл заах, багш нарыг чадваржуулах зэрэг олон төсөл хэрэгжих юм.

EDCF сангийн 25 сая ам.долларын зээлээр “Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн хоёрдугаар шатыг хэрэгжүүлэхээр болж, зээлийн хэлэлцээрт талууд гарын үсэг зурлаа. Дээрх төслийн хүрээнд Монгол Улс хот хоорондын тээвэрт зорнулж том оврын 200 автобус авч ашиглана. (Төслийн эхний шат амжилттай хэрэгжиж АСЕМ-д зориулан эхний ээлжинд манай улс шинээр 43 автобусыг БНСУ-ын “Эксим” банкны хөнгөлөлттэй зээлээр аван зочид төлөөлөгчдөд үйлчилж байна.) Төсөл хэрэгжсэнээр манай хот хоорондын тээврийн үйлчилгээ сайжрахад гадна автобусны засвар үйлчилгээ, тээврийн чиглэлийг боловсронгуй болгох зэрэг чиглэлд дэвшил гарах юм.

Соёлын салбарт хамтран ажиллах, цолжилтгүй тэмцэх болон эрчим хүч, эрүүл мэнд, мэдээлэл технологийн салбарт хамтран ажиллах тухай баримт бичгүүдэд гарын үсэг зурлаа. Хоёр орны хамтын ажиллагаанд шинэ салбар төслүүд нэмсэн дээрх баримт бичгүүд нь цаашид хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх өргөн боломжлолоо юм. Түүнчлэн агаарын харилцааны салбарын хамтын ажиллагааны хүрээнд Улаанбаатар-Пусаны чиглэлд энэ оны зургадугаар сараас эхлэн байнгын нислэг эхэлжээ. Ингэснээр хоёр орны иргэдийн зорчих урсгалыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ач холбогдолтой аж. Мөн соёл, боловсролын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Солонгосын Засгийн газрын тэтгэлгээр суралцах оюутны тоог нэмэгдүүлэх, манай иргэдийн БНСУ-д зорчих нөхцлийг улам хөнгөвчлөх, гэрээгээр ажиллах иргэдийн тоог нэмэгдүүлэх талархал БНСУ-ын Засгийн газрын зүгээс цаашид ч анхаарч, дэмжлэг үзүүлэхийг монголын тал хүсэлт болголоо.

Зүүн Хойд Азид оршдог орны хувьд Монгол Улс Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангид байлгах, бүс нутгийнхны энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, яриа хэлэлцээний сувгуудыг бүрэн ашиглахын тулхуудтай байр суурна яриа хэлэлцээний үеэр нотолсон. Тус бүс нутагт итгэлцлийг бий болгох, яриа хэлэлцээг бэхжүүлэх тухай “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилгын хүрээнд зохион байгуулсан бага хурал, чуулганд БНСУ төлөөлөгчдөө тогтмол оролцуулж ирснийг монголын тал өндөрөөр үнэлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар хийж буй БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ-ийн албан ёсны айлчлал өнөөдөр өндөрлөх юм.

minfo
МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчлалыг алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ


Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцт эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ



Гэрэл зургийг МОНГОЛЫН ТЭРЭЛ ЗУРАГЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО Т.АРГУУЖИН

Дугаарын **60** мөр

Риогийн тэнгэрт төрийн далбаагаа намирахыг харах л үлдлээ

Үргэлжлэл. Түүрүүч нь 1 нүүрт

Тамирчид олимпын наадам эхлэхээс 10 хоногийн өмнө РиО-д очсон байх учиртай тул одоогоор эх орондоо бэлтгэл сургуулилтаа чамбайруулж байгаа. Өнөөдрийн байдлаар, жудо 13, чөлөөт бөх 10, бокс зургаа, буудлага гурав, таэквондо, хүндийг өргөлт, байт харваа тус бүр нэг, хөнгөн атлетик дөрөв нийтдээ 39 тамирчин Рио-2016 олимпын эрхээ хүртээд байна. Усанд сэлэлтийн төрөлд хоёр тамирчин ОУОХ-ны урилгаар оролцох нь тодорхой болсноор өнөөдрийн байдлаар энэ тоог 41 тамирчин гэж албан бусаар зарлаж болохоор болоод байгаа юм. Мөн Паралимпийн тамирчдын амжилт ч чамлахааргүй. Манай тамирчид "Рио-2016" паралимпод таван төрөлд найман тамирчнаа сойно. Үүнд, пара байт харваа гурав, пара жудо бөх хоёр, пара буудлага, пара хөнгөн атлетик, пара пауэрлифтинг тус бүр нэг тамирчин оролцоно. Үүнээс гадна Эрүүл мэнд, спортын сайдын тушаал гарч, олимпод оролцох бөгөөд тамирчид, албаны хүмүүсийн тоог тогтоож өгсөн. Нийтдээ 110 хүн явах юм билээ. Түүнчлэн энэ жилийн хувьд нэг онцлог байгаа нь багийн бүрэлдэхүүнд тусгай бэлтгэгдсэн тогооч явах гэж байгаа юм. Тусгайлан хоол хүнс бэлтгэх, тамирчиддаа зориулсан хоол унд хийх шаардлага гарвал тус бэлтгэл хангагч тогооч нар ажиллах юм гэнэ билээ.

Мөн Өмнөд Америкийн Рио де Жанейро хот бөмбөрцөгийн нөгөө талд оршдог хот учраас жаахан хүндрэлтэй байх талаар албаны хүмүүс хэлж байсан. Гэхдээ олимп тэндхийн өвлийн улиралд болно. Өвлийн улиралдаа тэнд 20-нод хэм хүртэл л халдаг болохоор манай тамирчдад нэг их хүндрэл гарахгүй байх магадлалтай. Хэрэв зуны улирал таарсан бол тэнд 40 градус хүрч халдаг болохоор ихээхэн хүндрэл гарах байсан нь дамжиггүй. Түүнчлэн цагийн зөрүүний тухайд манайхаас 13 цагийн зөрүүтэй байдаг бөгөөд спортын чиглэлийн анагаах ухаан хөгжсөн орнуудад цагийн зөрүүг яаж арилгахыг тогтооцхсон байдаг, тэгээд ч манай тамирчид 13 хоногийн өмнө тэнд очиход цагийн зөрүү бүрэн арилна хэмээн тооцож байгаа юм билээ. Тэгэхээр манай тамирчид медалийн оосроос атгах бүрэн боломжтой болно гэсэн үг. Магадгүй Бээжингийн олимпоос ч их амжилт үзүүлнэ гэдэгт монголчууд найдаж буйгаа хэлж байгаа юм. Тэгэхээр бидэнд харуцлагатай, бас нэг том ажил үлдээд байгаа нь энэ. Тун удахгүй буюу энэ сарын 20-нд "Рио 2016" олимпын наадамд оролцох Монголын тамирчдыг үдэн гаргах ёслол Чингисийн талбайд болно. Тиймээс бид тамирчдынхаа захыг мушгиж, Риогийн тэнгэрт Монголынхоо төрийн далбааг намирахыг харах л үлдлээ дээ.

ЖАН КЛОД ЮНКЕР: Ц.ЭЛБЭГДОРЖ БОЛ МОНГОЛООС ТӨРСӨН ДЭЛХИЙН УДИРДАГЧ

Ж.ОТГОН

Монголчуудын хувьд түүхэнд тэмдэглэгдэн үлдэх тод үйл явдлууд өрнүүнтэй өдрүүдийг өнгөрүүлж байна. Тулгар төрийн 2225, Их Монгол Улсын 810, Ардын хувьсгалын 95 жилийн ойн үндэсний их баяр наадам өргөн дэлгэр сайхан болж, өндөрлөлөө. Энэ жилийн наадамтай залуудад л Монгол Улс АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг зохион байгуулж, Ази Европын орнуудын төрийн тэргүүнүүдийг нийслэлдээ хүлээн авч, нэгэн дэвээр дор цуглуулж чадлаа. Азийн цээжинд орших босоо бичигтэй, давтагдашгүй өвөрмөц өв соёлтой нүүдэлчин, хурдацтай хөгжин дэвшиж байгаа шинэ цагийн Монгол Улс гэдгээ дэлхий дахинд зарлан тунхаглаж, АСЕМ-аар нотолж, таниулж бас харуулж чадлаа. Дээд түвшний энэхүү уулзалтад АСЕМ-ын гишүүн 51 орон, хоёр олон улсын байгууллагын 4000 гаруй төлөөлөгч оролцохоор хүрэлцэн ирсэн. Төрийн тэргүүний түвшинд нийт 10 орны Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч, Засгийн газрын тэргүүний түвшинд нийт 23 орны Ерөнхий сайд, Шадар сайд, түүнчлэн 17 орны Гадаад хэргийн сайд болон бусад сайд, Тусгай элч, Элчин сайд нар манай улсад хүрэлцэн ирсэн нь онцгой үйл явдал. Тиймээс ч дэлхийн таван тэрбум хүн сайхан Монгол орон, амгалан Монгол орны тухай ярьж сонсч, ёстой л дэлхийн Монголоор амьсгалж байв, энэ өдрүүдэд.

...БНХАУ манай улсын Засгийн газрын 38 тэрбумын өрийг тэглэв. Мөн хоёр улсын хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд болох худалдаа, эдийн засаг, дэд бүтэц, эрчим хүч, санхүү, хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуй зэрэг салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх зарчмын тохиролцоонд хүрч, дараах 10 гаруй баримт бичиг байгууллаа...

үзэж байсан юм. Тэгвэл Монгол Улсын маань төрийн тэргүүн энэ эрхийг авч чадсан шигээ, нүүр бардам, итгэл төгс зохион байгуулж чадлаа. Энэ ажилд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх А.Баттөр, Гадаад хэргийн сайд Д.Пүрэвсүрэн, Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг нарын оролцоо их байж, тэд ч сайн зохион байгуулж, Ерөнхийлөгчийн итгэлийг алдалгүй ажиллаж чадсаныг онцлон дурьдах хэрэгтэй. Мөн АСЕМ-ын уулзалтын зохион байгуулалтад ойролцоогоор 12 мянга гаруй хүн гар бие оролцсон гэсэн тоо гараад буй. Төрийн албаныхан, сайн дурынхан, төрийн бус байгууллагуудынхан,

бүтээгдэхүүнээрээ туслахаа үзүүлсэн үндэсний үйлдвэрлэгч компаниуд, үүрэн холбооны операторууд, хандивлагчид, хувийн хэвшлийнхэнд болон бодит мэдээллийг шуурхай түгээж, улс орноо сурталчилсан хэвлэл мэдээллийнхэн гээд хувь нэмэр оруулсан бүх хүний хүчин зүтгэлийг энд дурьдах нь зүйтэй. Гэтэл нэгэн үе АСЕМ-ыг амтай болгон л харааж байсан. Харин одоо амтай болгон шахам магтаж байна. Үүнийг монголчуудын л араншин гэж бодоод өнгөрүүлж болохгүй. Учир нь улс төрийн их олимпоос бидний цөөхөн монголчууд хожиж, нийгээрээ нэг аххлаа. Дэлхийн дайдын асуудлыг улс гүрнүүдийн тэргүүнүүд Монголд чуулж хэлэлцээд. Энэ бол бидний тусгаар тогтнолын хамгийн том баталгаа. Тиймээс ч энэ үйл явдлыг эх орондоо болгох гэж тэмцэж муу, сайнаар олон удаа дуудуулж, энэ үйл хэргийг бүтээж чадсан Ерөнхий сайд асан Ч.Сайханбилэг, УИХ-ын дарга З.Энхболд, АСЕМ-ыг нүүр улайхааргүй явуулах гэж ачааны хүндийг үүрч ажилласан Хотын дарга Э.Баг-Уул, ИТХ-ын дарга Д.Баттулга болон түүний багийнхныг ч дурьдахгүй өнгөрч болохгүй.

АСЕМ-ийн дээд түвшний уулзалтад дэлхийн хүн амын 62.3, GDP-ийн 57.2 хувийг бүрдүүлдэг Евразийн хэвлэл мэдээлэл тэр чигтээ Монголд цугласан. Олон улсын мэдээллийн төвд 700 гаруй сэтгүүлч, зураглаачид ажиллаж, дэлхий дахинд Монголын талаархи эерэг мэдээллийг түгээсэн. Үүнийг ч Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж онцолж, "Хоёр тивийн удирдагчид нэгдэж чадлаа. АСЕМ-ын уулзалтын үеэр Монгол Улс зохион байгуулагчийн хувьд соёл уламжлалаа танилцуулж наадам зохион байгууллаа. Дараагийн удаа АСЕМ-ын уулзалт бараг 100 жилийн дараа Монгол Улсад зохион байгуулагдаж магадгүй. Сэтгүүлч нар маань маш сайн ажиллалаа. Дэлхийн 1.5 тэрбум хүн та бүхний

бэлтгэсэн мэдээллийг үзсэн. Та бүхэн Монгол оронтой танилцаж амжсан байх гэж найдаж байна. Та бүхнийг эргэж ирэх байх гэдэгт итгэлтэй байна" хэмээн хэлж байлаа. Үүнэн хэрэгтээ АСЕМ-ыг зохион байгуулснаар Монголыг харах өнгө өөрчлөгдөж, монголчуудад хандах ертөнцийн хандлага ч эерэг болж, бас ч үгүй тэдний олонхи нь монголчуудаар, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр бахархсан нь дамжиггүй. Тиймдээ ч Ц.Элбэгдорж ерөнхийлөгч Хубилай хаанаас хойш дэлхийн удирдагчдыг эсгий гэрт цуглуулсан хүн болж, түүхэнд тэмдэглэгдлээ. Түүний гавьяаг үнэлэх нь зөв.

Түүгээр ч барахгүй АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалт, тэр дундаа АСЕМ-ын 20 жилийн ойг эх орондоо зохион байгуулснаар бидэнд маш олон боломжүүд нээгдлээ. Тухайлбал, БНХАУ манай улсын Засгийн газрын 38 тэрбумын өрийг тэглэв. Мөн хоёр улсын хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд болох худалдаа, эдийн засаг, дэд бүтэц, эрчим хүч, санхүү, хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуй зэрэг салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх зарчмын тохиролцоонд хүрч, дараах 10 гаруй баримт бичиг байгууллаа. БНХАУ-аас гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалтад зориулж 350 сая юань буюу 100 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж олгохоор болсон. БНСВУ-аас сайн чанарын арьс боловсруулах хоёр үйлдвэрийг манай улсад байгуулж өгөхөөр боллоо. Сингапур, Монголын иргэд харилцан визгүй зорчих болов. Мөн Социалист Вьетнамын талаас Богд хааны ордон музей, Чойжин ламын сүм музейг сэргээн засварлах, Польш уул уурхайгаас бусад салбарт хөрөнгө оруулах боломжтой нэг сая еврогийн зээл олгох, Словак улстай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, Казахстан улс Баян-Өлгий аймгийн иргэдэд 200 мянган ам.долларын хандив өгөхөөр болсон гээд дурьдаад байвал нэлээд урт жагсаалт гарна. Ийнхүү олон талын үр

МЭДЭЭЛЭЛ

САЙД ЯРЬЖ БАЙНА



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Үргэлжлэл.
Түүрч нь 1 нүүрт

Үүнд, зам талбай, тохижилтын ажил, нислэг үйлдвэрлэл, нисэх буудлын үйлчилгээний чиглэлээр, харилцаа холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад тодорхой ажлуудыг хэрэгжүүлж ажилласан.

–Гурван үндсэн чиглэлийн ажлыг хариуцан гүйцэтгэж ажилласан гэлээ. Зам талбай, тохижилтын ажлын хүрээнд ямар ямар ажлууд хийгдсэн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

–Үндэсний зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Улаанбаатар хотын өнгө үзэмж, тохижилтыг сайжруулахаар далайцтай ажлуудыг

төлөвлөж хэрэгжүүлсэн. Тухайлбал, дээд түвшний уулзалтын зочид төлөөлөгчдийн явах гол замуудыг засварлах, шинэчлэх, тохижуулах зорилгоор Баянзүрхийн товчооноос Яармагийн гүүрний урд уулзвар хүртэлх 13.7 км замын гэрэлтүүлэг, Яармагийн гүүрнээс “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал хүртэлх замын гэрэлтүүлэг, Их Монгол Улсын гудамжны 2.1 км авто зам, Гандийн гудамжны авто зам, Зайсангийн гудамжнаас Жапан таун хүртэлх авто зам, Баянмонгол хорооллын урд талын Хүннүгийн гудамжны 1.1 км авто зам, Энхтайваны гүүрний зүүн талын туслах замаас Соул ресторан, Хүүхдийн паркийн дундуур Олимпын гудамж, Гэндэнгийн гудамж хүртэлх авто зам, Богд уулын арын авто зам 17.1 км авто

М.ЗОРИГТ: АСЕМ-ЫГ ӨӨРИЙН УЛСАД САЙН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХАРИУЦЛАГАТАЙ АЖИЛД ЗТЯ ЧУХАЛ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ ОРОЛЦЛОО

зам, Яармагийн гүүр-Нисэхийн товчоо, Сонсголгогийн уулзвараас Яармагийн товчоо хүртэлх 13.7 км авто зам зэрэг авто замуудад засвар шинэчлэлт, тохижилтын ажлуудыг гүйцэтгэсэн. Дээрх зам талбайн ажилд шаардлагатай нийт 82917 тэрбум төгрөгийн хөрөнгийн асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 53 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн бөгөөд Зам, тээврийн сайдын 2016 оны хоёрдугаар сарын 05-ны өдрийн эрх шилжүүлэх тухай 31 дүгээр тушаалаар тус ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянах, баталгаажуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавих эрхийг нийслэлийн Засаг даргад шилжүүлсэн. Мөн нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар болон нийслэлийн Авто замын газраас дээрх ажлуудын худалдан авалт, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажилласан.

–АСЕМ-ын уулзалтад хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчид хамгийн түрүүнд “Чингис хаан” олон улсын нисэх буудалд буусан. Тэгвэл нислэг үйлдвэрлэл, нисэх буудлын үйлчилгээний чиглэлээр ямар ажлууд хийгдэв?

–Дээд хэмжээний зочид төлөөлөгчдийг угтан авах, үдэн гаргахад Монгол Улсын үүд хаалга болсон “Чингис хаан” олон улсын нисэх буудлын өнгө үзэмж, үйл ажиллагааг сайжруулах, нислэгийн аюулгүй байдлыг хангахад онцгой анхаарал хандуулж ажилласан. Энэ хүрээнд “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх, засварын ажлуудыг гүйцэтгэхэд шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Зам тээврийн сайдын 2015 оны аравдугаар сарын 09-ний 263 дугаартай тушаал гарч Улсын төсвийн хөрөнгө болон Иргэний нисэхийн ерөнхий газрын 2013-2014 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн үлдэгдэл хөрөнгөөр нийт 43 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн дээд түвшний уулзалтыг зохион байгуулахад нисэх буудлын үйлчилгээний бэлтгэл ажлыг хангах урьдчилсан төлөвлөгөөг Зам, тээврийн сайд баталсан. Төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг

гүйцэтгэсэн байна. Үүнд, шинээр транзит танхим байгуулсан. Транзит танхимын бүтээн байгуулалт нийтдээ 2000 гаруй м.кв талбайг хамарч, нисэх буудал цагт 800 орчим зорчигчид үйлчлэх хүчин чадал нь 1200 орчим зорчигчид үйлчлэх хүчин чадалтай болж нэмэгдсэн. Зочид төлөөлөгчдийн угтах, үдэх үйлчилгээнд нисэх буудлын үйлчилгээний нийт 45 ажилтанг сургалтад хамруулсан. Нисэх буудлын өнгө үзэмж, үйлчилгээг сайжруулах зорилгоор ариун цэврийн өрөөнүүдийг засварлаж хөгжлийн бэрхшээлтэй зорчигчид зориулсан тусгай кабинудыг бий болгосон, гадаад хүндэт зочны танхимд засвар тохижуулалт хийсэн, Олон улсын хүлээх танхим, агаарын хөлөгт суух хоолойн хэсгийн засвар, тохижуулалт, зорчигчийн тээш, гар тээшинд зориулагдсан бага, том оврын нийт 100 ширхэг тэргэнцэр нийлүүлсэн, хилийн шалган нэвтрүүлэх ажилтнуудын кабинудыг шинэчилсэн зэрэг олон ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн нислэг үйлдвэрлэл, аэродромын үйлчилгээний хүрээнд нэлээд томоохон ажлуудыг гүйцэтгэсэн. Тухайлбал, “Чингис хаан” олон улсын нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай зурвасын 500 метрийн хүчигтэл хийсэн, нисэх буудлын перроны өргөтгөл/агаарын хөлгийн өсөн зогсоол/-ийн ажил хийж нийт 34 агаарын хөлгийн зогсоолтой болсон. Мөн агаарын хөлгийн газрын үйлчилгээний 6.1 тэрбум төгрөгийн өртөгтэй 20 тоног төхөөрөмж тоног төхөөрөмжийг худалдан авсан. Дээд хэмжээний уулзалтын нислэгийн аюулгүй байдлыг хангах тусгай ажлын хэсэг ИНЕГ-ын даргын тушаалаар томилог ажиллуулж, онцгой үүргийн нислэгүүдийн зохицуулалтыг олон улсын болон дотоодын хуваарьт нислэгүүдийн цагийн хуваарийн зохицуулалтыг хийж ажиллалаа. Олон улсын хуваарьт нислэгээр явах болон ирэх энгийн зорчигчдыг “Баянт Ухаа” спорт цогцолбор-“Чингис хаан” ОУНБ хооронд зөвөрлөх зам, маршрутгүй гарган автобусаар үйлчлэх ажлыг зохион байгуулаа. Аюулгүй байдлын тал дээр ч нэлээд анхаарал хандуулсан. Дээд түвшний зочид төлөөлөгчдийн нислэгийн болон нисэх буудал дахь

аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн өргөн хүрээний цогц үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Энэ хүрээнд АСЕМ-ын үеэр “Чингис Хаан” ОУНБ-ын аюулгүй байдлын нийтийн эзэмшлийн болон тусгай үүргийн нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй бүсэд аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, нэгдсэн ажлын төлөвлөлт гарган хэрэгжүүлж ажиллалаа. Үүнээс гадна харилцаа холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад тодорхой ажлуудыг хэрэгжүүлж ажиллаж чадлаа. Тодруулбал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газраас Үндэсний дата төвд тоног төхөөрөмж, систем суурилуулах ажлыг гүйцэтгэсэн. Мөн уулзалтын үеэр ажиллах Мэдээллийн төв шаардлагатай зарим тоног төхөөрөмжийг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газраас суурилуулах ажлыг гүйцэтгэсэн гээд нэлээд томоохон ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэлээ.

–Зочид төлөөлөгчдийн тээвэрлэлтэд танай яам томоохон хувь нэмэр оруулсан тухай мэдээлэл бий. Шинээр хэдэн автобус авсан бэ. АСЕМ-д зориулж авсан автобусыг хот хоорондын нийтийн тээвэрт явуулна гэсэн. Үнэн үү?

–БНСУ-ын Экспорт-Импорт банкны зээлээр авахаар төлөвлөж буй улс, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээнд зориулсан их багтаамжийн 300 автобусыг АСЕМ-ын уулзалтын үеэр ашиглах боломжтой гэж үзэн эхний ээлжинд Хьюндай загварын 43 автобусыг зургадугаар сард багтаан БНСУ-аас оруулж ирсэн. Эдгээр автобусууд нь зочид төлөөлөгчдийн тав тухтай үйлчилгээнд чухал хувь нэмэр оруулж ажилласан. Автобусаар үйлчлэхтэй холбогдуулан 50 жолоочийг тусгай сургалтад хамруулсан бөгөөд дөрвөн инженерийг байнгын бэлэн байдалд ажиллуулсан. Эдгээр автобусуудыг хурлын зочид үйлчилсний дараа улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжид хуваарилах өгнө.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОР БАЙГУУЛАХЫН ТУЛД НИЙТ 32 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

–15 дахь удаагийн Ази–Европын бизнес уулзалт “Оролцоотой хөгжлийн уялдаа холбоо” сэдвийн дор амжилттай зохион байгуулагдлаа–

АСЕМ-ийн дээд түвшний уулзалтын дагалдах хурлуудын сүүлчийн уулзалт болох “Ази, Европын бизнесийн 15 дугаар чуулга уулзалт”-ыг Аж үйлдвэрийн яам, Гадаад хэргийн яам, МҮХАҮТ хамтран энэ сарын 13, 14-ы өдрүүдэд Төрийн ордны Их танхимд зохион байгууллаа. 15 дахь удаагийн “Ази, Европын бизнесийн чуулга уулзалт”-д нийт 40 гаруй орны 700 орчим зочид, төлөөлөгчид оролцсоны дотор БНВУ-ын Ерөнхий сайд ноён Нгуен Суан Фук, Европын холбооны Ерөнхийлөгч Жан Клод Юнкер нар байлцав.

Чуулганы үеэр “Торгоны зам” буюу “Талын зам”, гурван улсын эдийн засгийн коридор, хоёр тивийн дунд Монгол Улсын гүйцэтгэх үүрэг, оролцооны талаар онцлон ярилцлаа. Тухайлбал, гурван улсын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд нийт 32 төслийг ирэх таван жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр болсныг нь ч энэ үеэр дуулгалаа. Түүнчлэн чуулганд оролцогчид бизнес хөрөнгө оруулалтын тухай асуудал, ЖДҮ-ийг хөгжүүлэх, дэд бүтэц, байгаль экологийг хамгаалах тухай хэлэлцэж, Монгол Улс хоёр тивийн дунд орших сэргээгдэх эрчим хүчний асар том түшиц газар хэмээн тодорхойллоо.

Чуулга уулзалт хоёр өдрийн турш үргэлжилсэн бөгөөд “Оролцоотой эдийн засгийг хөгжүүлэх”, “Ази-Европын уялдаа холбоо”, “Жижиг, дунд бизнес олон улсын нэмүү өртгийн сүлжээнд нэгдэх”, “Хөрөнгө оруулалт ба ногоон хөгжил” сэдвийн дор зохион байгуулагдав. Бизнесийн чуулга уулзалтыг нээж Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат үг хэлсэн юм. Тэрбээр энэ удаагийн чуулганыг “Ази, Европ хоёр тивийн эдийн засаг, худалдаа бизнесийн бат бөх түншлэл, харилцан ашигтай хамтын ажиллагааг дэмжих чухал индэр” хэмээн тодорхойлсон юм.

Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат цааш хэлсэн үгэндээ “Хөгжиж буй орнуудын төлөөлөл болсон Монгол Улс өөрийн улсын эдийн засгийн бие даасан байдал, тогтвортой өсөлтийг бий болгохоор уул уурхайн түүхий эдийн экспортлогч, хэрэглээний эдийн засагтай орноос өөрийн баялгийн нөөцөд тулгуурласан бүтээгч эдийн засаг руу шилжиж байна. Тиймээс ч бид эдгээр санаачлагад нэгдэн, харилцан ашигтайгаар эдийн засгаа хөгжүүлэх үүднээс энэ удаагийн бизнес уулзалтыг “Оролцоотой хөгжлийн уялдаа холбоо” гэсэн нэгдсэн сэдвийн хүрээнд зохион байгуулж байна” гэв.

Монгол Улсыг дэлхий дахинд сурталчлан таниулах онцгой ач холбогдол бүхий арга хэмжээ болсныг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хаалтын үеэр онцлон тэмдэглэлээ. Чуулганаас гарсан санал, дүгнэлтийг “Чуулга уулзалтын зөвлөмж” болгон төлөөлөгчдөөр батлуулан АСЕМ-ын дээд түвшний уулзалтад хүргүүлжээ.

Туркт болсон бослогод монгол иргэд өртөөгүй гэв

Монгол дахь Бүгд Найрамдах Турк улсын Элчин сайдын яамнаас хэвлэлийнхэнд Турк Улсад үүсээд байгаа нөхцөл байдлын талаар мэдээлэл хийлээ. Бүгд найрамдах Турк улсад энэ сарын 15-16-нд шилжих шөнө цэрэг армийнхан төрийн эргэлт хийхийг оролдож, тус улсын нийслэл Анкара болон Истанбул хотуудад эмх замбараагүй байдал үүссэн. Төрийн эргэлт хийхийг оролдох үеэр бослого гаргасан 100 орчим цэрэг, мөн хамгаалалтад гарч байсан цагдаагийн байгууллагын 42, энгийн 118 хүн амиа алдаж, 1400 орчим иргэн шархдаж эмнэлэгт хүргэгдсэн

байна. Шархдаж, нас барсан иргэд дунд гадны улсын иргэд байсан эсэх мэдээлэл одоогоор Элчин сайд Мурад Карагөзд ирээгүй аж. Гэхдээ Монгол иргэд дээрх халдлагад өртөөгүй гэж Монгол Улсад суугаа Турк улсын Элчин сайд мэдэгдлээ. Туркт Монгол Улсаас 3000 орчим иргэн амьдардаг. Ихэнх нь Анкара, Стамбулд төвлөрсөн гэв. Турк улсад цэргийнхэн бослого гаргаж эхлэх тэр үед тус улсын Ерөнхийлөгч Режеп Тайип Эрдоан Станбулаас зайтай амралтын газар байжээ. Төрийн эргэлтийн талаарх цэргийнхний халдлагыг тагнуулын байгууллагаасаа

сонсонгуутаа Станбул хотод нисдэг тэргээр ирсэн байна. Энэ үед нь бусад эх баригчид нь Анкара дахь агаарын цэргийн базад барьцаалгдсан байсан гэж Монгол Улсад суугаа Турк улсын Элчин сайд ярилаа. Мөн Турк улсын Ерөнхийлөгч Режеп Тайип Эрдоан энэхүү гэнэтийн халдлага буюу төрийн эргэлтийг АНУ-д байрлах Исламын номлогч Фетхуллах Гюленыг удирдсан гэж үзжээ. Тэрбээр АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамад нэр бүхий этгээдүүд төрийн эргэлт хийхийг санаархаж эхэлсэн тухай өмнө нь хэлж байсан. Хэдий тийм боловч бидний

үгэнд АНУ-ын эрх баригчид итгээгүй. Харин өчигдөр, төрийн эргэлт хийх оролдлогын дараа Пеннсилванид буй этгээдийг Турк улсын хууль хэрэгжүүлэгчдэд шилжүүлэхийг шаардаж байна. Бид АНУ-ын хусалтийн дагуу террорист этгээдийг шилжүүлж байсан. Тиймээс Турк улсын нэн аюултай этгээдийн жагсаалтад бүртгэлтэй этгээдийг шилжүүлэхийг хүсч байна гэж мэдэгджээ. Харин АНУ-ын тал Фетхуллах Гюленыг Туркт шилжүүлэхийн өмнө баталгаатай баримтаар нотлох ёстой гэсэн байр суурийг илэрхийлээд байгаа аж.

Л.ПҮРЭВСҮРЭН: АСЕМ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЧ ХОЛБОГДОЛ ОДООГООР 8-10 САЯ АМ.ДОЛЛАР БОЛЖ БАЙНА



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

АСЕМ-ын Дээд түвшний 11 дүгээр уулзалт Улаанбаатар хотноо амжилттай зохиогдож өндөрлөсөнтэй холбогдуулан Гадаадхэргийн сайд Л.Пүрэвсүрэн уг арга хэмжээг дүгнэж, уулзалтын үр дүн, Монгол Улсад үндэж буй бодит үр ашг, ач холбогдлын талаар сэтгүүлчдэд мэдээлэл өгжөө. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Ази-Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг зохион байгуулах, чиг үүргээр хангах үндэсний зөвлөл байгуулагдсанаас хойш

жил гаруйн хугацаанд өндөр дээд хэмжээний зочид төлөөлөгчдийг байрлуулах хотхон байгуулах, зочид буудлуудыг чадавхижуулах, хот тохижуулах, мэргэжилтэй ажилчид болон сайн дурын ажилтнуудыг бэлтгэх зэрэг олон чухал ажил хийгдсэнийг сайд Л.Пүрэвсүрэн мэдээллийнхээ эхэнд онцоллоо. АСЕМ-ын уулзалтын зохион байгуулалтын хүрээнд 4400 хүнийг мэргэшүүлсэн сургалтад хамруулснаас үйлчилгээний чиглэлээр 620 хүн, зочид



буудлын менежментийн чиглэлээр БНСУ-д 15 хүн, хурлын менежерээр 50 хүнийг гадаадад сургаж авч байна. Мөн олон улсын хурлын орчуулагчаар Энэтхэгт 14, Европын холбооны зардлаар 6 хүнийг мэргэжлийн түвшинд бэлтгэж, сайн дурын 1100 гаруй оюутан залуусыг сургалтад хамруулжээ. Түүнчлэн аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаа, тагнуулын 500 орчим хүнийг сургаж бэлтгэсэн байна. АСЕМ-ын уулзалтад зориулж улсын төсвөөс 2014, 2015 онд тодорхой хөрөнгө батлаагүй, харин 2016 онд 21 тэрбум төгрөг төсөвлөсөн бөгөөд энэ хөрөнгийг уулзалт зохион байгуулах байр танхим, зочид төлөөлөгчийн унаа, хот тохижилт, дэд бүтэц, аюулгүй байдлын хамгаалалтад ашиглагдах автомашин, тоног төхөөрөмж зэрэгт зарцуулснаа мэдээлжээ. АСЕМ-ын төлөөлөгчдийн нислэг, зочид буудал, бүтээгдэхүүн ханган нийлүүлэлт, үйлчилгээ зэргээс Монголд үлдэх эдийн засгийн ач холбогдлыг одоогоор 8-10 сая ам.доллар хэмээн тоймлоод байгаа бөгөөд удахгүй

нарийвчилсан тооцоо гаргах аж. Түүнчлэн АСЕМ-ыг амжилттай зохиосноор улс орныхоо нэр хүндийг дэлхийн түвшинд өргөөд зогсохгүй энэ бүх бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалт, дэд бүтэц, хүний нөөц, мэдлэг туршилага зөвхөн Монгол Улсад үлдэж, дараа дараагийн олон улсын арга хэмжээг зохион байгуулах хөрс суурь болж буй нь мөнгөн дүнгээр илэрхийлж боломгүй ач холбогдолтой болохыг сайд Л.Пүрэвсүрэн мэдээлэлдээ онцоллоо. Гадаад эргэлийн сайд мэдээллийнхээ төгсгөлд АСЕМ-ын уулзалтын зохион байгуулалтад ойролцоогоор 12 мянга гаруй хүн гар бие оролцсон, тэдгээр төрийн албаныхан, сайн дурынхан, төрийн бус байгууллагуынхан, бүтээгдэхүүнээрээ туслахаа үзүүлсэн үндэсний үйлдвэрлэгч компаниуд, үүрэн холбооны операторууд, хандивлагчид, хувийн хэвшлийнхэнд болон бодит мэдээллийг шуурхай түгээж, улс орноо сурталчилсан хэвлэл мэдээллийнхэн гээд хувь нэмэр оруулсан бүх хүнд талархал илэрхийллээ.

АСЕМ-11 ГЭРЭЛ ЗУРАГТ



Гэрэл зургийг МОНГОЛЫН ГЭРЭЛ ЗУРАГЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО, Г.АРГУУЖИН



ДЭЛХИЙ



People gather at a memorial for victims of the attack in Nice, France. (Eric Galliard/Reuters)

ХАЛДЛАГА, БОСЛОГОД ӨРТӨЖ, ОНЦ БАЙДАЛ ЗАРЛАСАН ДОЛОО ХОНОГ

Б.ДАВАА

Өнгөрсөн долоо хоногт дэлхий нийтийг цочроосон томоохон халдлагад Франц өртөж, Туркэд цэргийн бослого гарлаа. Энэ талаархи мэдээллийг тойлон хүргэе.

Францад халдлага болж, 84 иргэн амиа алдав

Франц улсын Ницце хотод энэ сарын 14-нд халдлага болж, 73 иргэн амиа алдсан харамсалтай хэрэг гарсан. Ницце хотын төвд ёслолын буудлага үзэхээр ирсэн хүмүүс рүү ачааны автомашин дайран орсны улмаас 73 хүн амиа алдаж, 50 хүний бие маш хүнд байна хэмээн CNN дамжуулсан юм. Ачааны автомашины жолоочийг цагдаагийнхан аюулгүй болгож, машинд нь нэгжлэг хийхэд тус ачааны автомашинаас тэрэх бөмбөг, буу зэвсэг олджээ. Уг хэрэг явдалтай холбогдуулан Ницце хотын захирагч онц байдал зарлаж, иргэдийг гэрээсээ гарахгүй байхыг анхааруулсан юм. Мөн үүсээд буй нөхцөл байдалтай холбогдуулан тус улсын Ерөнхийлөгч Франсуа Олланд, Ерөнхий сайд Манюэль Вась нар Ницце хотод очиж, нөхцөл байдалтай нь танилцсан. Тэгвэл тус улсын ерөнхийлөгч Ф.Олланд мэдэгдэл хийж, Франц улсад тогтоосон байсан онц байдлын хугацааг дахин гурван сараар үргэлжлүүлэх болсныг онцолсон. Мөн тэрбээр “Тэмт хэрэгтнийг барьж чадаагүй байна, гарлыг нь тодорхой болгож хамсаатнуудыг баривчлахын төлөө чадах бүхнээ хийнэ. Бид нэгдмэл байдлаа харуулж терроризмын эсрэг үйлдлээс ард иргэдээ хамгаалах ёстой. Франц улс харуул хамгаалалтаа сайжруулж, Сири, Ирак руу явуулах ажиллагаагаа үргэлжлүүлэх болно. Өнөөдөр Батлан хамгаалах зөвлөлийн уулзалт болно, терроризмын эсрэг авах бүхий л арга хэмжээг авна. Цаг тухайд нь энэ тухай зарлах болно. Франц бол хүчирхэг гүрэн, тэднээс илүү хүчирхэг байх болно. Францыг сөгдүүлж чадахгүй” гэсэн юм. Мөн халдлагад амь үрэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэн Франц улсын хэмжээнд долдугаар сарын 16, 17, 18-ны өдрүүдийг “Үндэсний гашуудлын өдөр” болгон зарласан. Нэг өдрийн дараах байдлаар халдлагад амиа алдсан иргэдийн тоог албан ёсоор гаргасан бөгөөд амь үрэгдсэн 84, тэдгээрээс 10 нь хүүхэд болон өсвөр насныхан, 202 хүнд бэртсэн хүмүүсээс 52 хүн маш эрсдэлтэй байна хэмээн тухай мэдээллийн агентлагууд дамжуулж байв.

Түүнчлэн халдлага үйлдсэн гэмт этгээдийг саатуулсан бөгөөд гэмт этгээд нь Mohamed Lahouaiej



...Ерөнхийлөгч Эрдоган хуйвалдаанд 130 гаруй хүн холбогдсоноос эхнээс нь баривчилж байгаа бөгөөд Засгийн газар эргэн хяналтыг гартаа аван, байдлыг хэвийн болгоно хэмээн мэдэгдсэн юм. Тэгвэл төрийн эргэлт хийх гэсэн оролдлоготой холбоотой хэмээн баривчлагдсан цэргийнхний тоо 1000 гараад байгаа тухай Туркийн тал мэдээлж, армийн өндөр албан тушаалын 30 гаруй хүнийг албан тушаалаас нь огцруулжээ...

Bouhlel, 31 настай, тунис гаралтай, террорист халдлагатай холбоотой байж болох талаар Францын тусгай албаныханд ямар нэгэн бүртгэлд ороогүй нэгэн байжээ. Франц улсад ийм эмгэнэлт явдал болсонтой холбогдуулан АСЕМ-ын Дээд хэмжээний 11 дүгээр уулзалтад оролцож байгаа Ази, Европын төр, засгийн тэргүүн нар, Европын зөвлөлийн Ерөнхийлөгч, Европын комиссын Ерөнхийлөгч, АСЕАН-ы ЕНБД нар Ази, Европ тив төдийгүй дэлхийн бусад өнцөгт террорист халдлага удаа дараа гарч байгааг онцлоод, терроризмын бүх хэлбэрийг буруушаан түүнтэй тууштай тэмцэхээ дуу хоолой нэгтгэж илэрхийлж, мэдэгдэл гаргасан юм. Уг мэдэгдэлд террорист халдлага үйлдэгчдэд НУБ-ын Дүрэм болон олон улсын бусад хууль тогтоомжийн дагуу хатуу шийтгэл ногдуулж, хариуцлага тооцох ёстойг

мэдэгдэж, терроризмтэй хүчээ нэгтгэн тууштай тэмцэхээ цохон тэмдэглэсэн бөгөөд Францын Ницце хотноо гарсан террорист халдлагын улмаас олон хүний амь нас үрэгдэж, нөхөж баршгүй хохирол учирсанд хохирогсдын ар гэр, ойр дотныхонд гүн эмгэнэл илэрхийлсэн юм.

Төрийн эргэлт хийхээр цэргүүд бослого гаргав

Францад халдлага болж, олон хүн амь эрсдэн гашуудаж байх үед буюу долдугаар сарын 15-16-нд шилжих шөнө Туркийн цэргийнхэн төрийн эргэлт хийхээр бослого гаргасан тухай мэдээлэл цацагдсан юм. Цэргийнхэн улс орноо захирах болсноо Туркийн төрийн мэдлийн TRT телевизээр зарлаж, “Үндэсний энх тайван” гэж өөрсдийгөө нэрлэсэн цэргийн зөвлөл эргэлт хийсэн хэмээн мэдэгдэлд өгүүлсэн байв. Харин Туркийн Ерөнхийлөгч Тайип Эрдоган гар утсаараа дамжуулан видео мэдэгдэл хийж, ард иргэдээ цэргийнхний эсрэг тэмцэхийг уриалсан бөгөөд “Цэргийнхний оролдлого амжилт олохгүй” хэмээн хэлсэн байна. Бослого өрнөж, Истамбул болон Анкара хотод буун дуу гарч, зарим газрыг цэргийнхэн хэсэгчлэн хааж, бүр парламентын ордны гадна танк зогсч байгаа талаар мэдээллийн сувгууд мэдээлж байсан юм. Тэгвэл Туркийн Ерөнхийлөгч Режеп Тайип Эрдоган Атагуркийн нисэх буудалд газардаж, мэдэгдэл хийв. Тэрбээр бослого гаргасан цэрэг арми, офицерүүдийг эхнээс нь баривчилж эхэлсэн тухай мэдэгдээд уг цэргийн эргэлт хийх гэсэн оролдлого нь хэсэг бүлэг офицеруудын хуйвалдаанаас үүдэлтэйг дурдаад нийт цэрэг арми оролцсон нь ташаа мэдээлэл болохыг онцлоод, “Улс орныхоо эсрэг боссон эдгээр хүмүүс Бүгд Найрамдах Турк улсын бүрэн эрх болоод ардчилал, амар тайван байдалд заналхийллээ.

Эдгээр хүмүүстэй зөвшилцөх боломж байхгүй. Тэд ийм үйлдэл гаргасныхаа шанг хүртэх ёстой. Төрийн далбаа минь миний нэр төр. Эх орон минь миний нэр төр. Тиймээс ч би өнөөдөр үхэхэд ч бэлэн ирлээ. Улс орныхоо төлөө энэ амь биеэ зориулахад би бэлэн байна” хэмээсэн.

Ерөнхийлөгч Эрдоган хуйвалдаанд 130 гаруй хүн холбогдсоноос эхнээс нь баривчилж байгаа бөгөөд Засгийн газар эргэн хяналтыг гартаа аван, байдлыг хэвийн болгоно хэмээн мэдэгдсэн юм. Тэгвэл төрийн эргэлт хийх гэсэн оролдлоготой холбоотой хэмээн баривчлагдсан цэргийнхний тоо 1000 гараад байгаа тухай Туркийн тал мэдээлж, армийн өндөр албан тушаалын 30 гаруй хүнийг албан тушаалаас нь огцруулжээ. Үүн дотор таван генерал, 29 хурандаа байсан байна. Зарим цэргийн

эрхтнийг удирдлагад нь байдаг цэргүүд нь баривчилж холбогдох байгууллагад тушаасан гэсэн мэдээ байгаа юм. Улс орон даяар баривчилгаа үргэлжилж байна. Туркийн Ерөнхийлөгч Режеп Тайип Эрдоган Туркийн сөрөг хүчний номлогч Фетхуллах Гюлшенийг бослогод холбоотой хэмээн хэлсэн ч Гюлшен үүнийг няцааж, “Туркэд төрийн эргэлт хийх оролдлого гарсаныг би шийдвэртэй буруушааж байна. Цэргийн эргэлтийг нэг бус удаа үзэж байсан хүний хувьд ийм бослогод буруутгагдаж байгаадаа эмзэглэж байна. Намайг ийнхүү буруутгаж байгааг би няцааж байна” хэмээсэн байв. Мөн Истамбулын Босфорын хоолойг холбосон гүүрийг эзлээд байсан цэргийнхэн бууж өгсөн байна. Туркэд өрнөж буй бослого, үймээний талаар тус улсын Дотоод Хэргийн яамнаас сүүлийн үеийн мэдээлэл хийлээ. Туркийн үндэсний мэдээллийн Анадолю агентлагийн дамжуулсанаар бослогод оролцсон 754 хүнийг баривчлан саатуулсан байна.

Мөн Туркийн нийслэл Анкара хотод яг одоо 800 хүн, Истамбул хотноо 200 хүн эмнэлэгт хүргүүлэн эмчилгээ хийлгэж байгаа тухай “Улаан хавирган сар” нийгэмлэгийн тэргүүн Керем Киник твиттер хуудсаар дамжуулан мэдээлжээ. Бослогын улмаас 42 хүн амь насаа алдаж, 1000 гаруй хүн бэртэж гэмтээд байгаа ажээ. Цэргийн эргэлт хийх оролдлого гарсны дараа Туркийн ард иргэд ардчиллаа хамгаалахыг эрх баригчдаас хүсч жагсаал хийлээ. Туркийн Истамбул болон бусад хотуудад олон мянган хүн төрийн далбаагаа барин гудамжинд жагсаал хийсэн байна. Ерөнхий сайд Бинали Йылдырым цэргийн эргэлт Туркийн

ардчилалд хар толбо үлдээлээ хэмээн мэдэгджээ. Турк улсад цэргийн эргэлт гарсан шалтгаан нь дотооддоо хуваагдсан явдал юм. Хөрш Сири улсад олон жил үргэлжилсэн иргэний дайны нөлөө болон ерөнхийлөгч Режеп Тайип Эрдоганы Туркийг өөрчлөх, эрх мэдлээ нэмэгдүүлэх оролдлого нь хуваагдлын гол шалтгаан байсан ажээ.

Египетийн онгоцонд гал гарсны нотлох

Газар дундын тэнгист өнгөрсөн тавдугаар сард сүйрсэн Египетийн “EgyptAir” компанийн онгоцонд гал гарсныг хар хайрцгийн бичлэгээр нотолжээ. Нислэгийн бүхээгийн дуу хураагч хар хайрцгийн бичлэгт онгоцны кабинд гал гарсан тухай хүмүүсийн яриа бичигдсэн байна. Түүнчлэн Газар дундын тэнгисээс олдсон нисэх онгоцны сэгэнд өндөр температурын улмаас гэмтсэн ул мөр үлджээ. Гэхдээ мөрдөн шалгах комисс галын шалтгааныг хараахан тодруулаагүй байгааг мэдэгджээ. Нисэх онгоц радарын дэлгэцнээс алга болохын өмнө утаа гарсан гэх автомат дохиог илгээсэн байснаас гал гарсан гэх таамгийг урьдчилан дэвшүүлсэн байсан юм. Францын Парис хотоос Канр руу буцаж явсан “Airbus A320” онгоц өнгөрсөн тавдугаар сарын 19-нд Газар дундын тэнгист сүйрснээс 66 хүн амь үрэгдсэн билээ. Нисэх онгоцны сэг болон зорчигчдын цогцос, эд зүйлс Египетийн Александриа боомт хотоос 290 км орчим зайтай тэнгисээс олджээ. Түүнчлэн онгоцны их бие тэнгисийн 3000 орчим метрийн гүнд байгааг олж илрүүлсэн байна.

ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ ЗАР

“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны зургадугаар сарын 15-ны өдрийн 233 тоот “Багануур ХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай тогтоол”-оор компанийг нэмж гаргасан хувьцааг бүртгэхийг зөвшөөрсөн бөгөөд компани нь нийт 9.870.287 /есон сая найман зуун далан мянга хоёр зуун наян долоо/ ширхэг хувьцаа нэмж гаргахаар шийдвэрлэсэн.

Энэхүү үйл ажиллагаатай холбогдуулан 2016 оны дөрөвдүгээр сарын 18-ны өдрийн 25 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Багануур ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрхийг хэрэгжүүлэх журам”-ыг үндэслэн, компанийн 2015 оны арваннэгдүгээр сарын 5-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож амжаагүй эсхүл хурлаас гарсан шийдвэртэй эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүсээд байна.

Иймд “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигч та бүхэн уг шаардах эрхээ хэрэгжүүлэх бол компанид хандана уу.

-Хувьцааг эргүүлэн худалдаж авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2015.11.05

-Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах хүсэлт хүлээн авах эцсийн өдөр: 2016.08.15

“Багануур” ХК-иас хүсэлт хүлээн авах мэргэжилтний мэдээлэл:

УЛААНБААТАР ХОТ, БАГАНУУР ДҮҮРЭГ, “БАГАНУУР” ХК-ИЙН ӨӨРИЙН БАЙР, 2 ДАВХАР, 201 ТООТ ӨРӨӨ
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТАН С.ОДОНЧИМЭГ, УТАС:99044373
ЭЛЕКТРОН ШУУДАН: SANJAA_OOGII@YANOO.COM

ШУУРХАЙ МЭДЭЭ

ИРГЭД УХАМСАРГҮЙ ҮЙЛДЛЭЭСЭЭ БОЛЖ УСАНД ОСОЛДОХ НЬ ИХЭССЭН

Н.БАТЗАЯА

ОБЕГ-ын Галигийн шуурхай удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Ж.Далдинсүрэнгээ голын усны түвшин нэмэгдсэн эсэх болон Баян-Өлгий аймагын Өлгий суманд болсон үерийн тухай зарим зүйлийг тодруулаа.

-Өнгөрсөн өдрүүдэд нийт нутгаар бороо орсон. Борооны улмаас хэд хэдэн голын усны түвшин нэмэгдэж, аюултай байдал үүссэн. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу. Ямар голын усны түвшин нэмэгдсэн бэ?

-Үндэсний баяр наадмын өдрүүдэд орсон борооны улмаас томоохон голуудын түвшин нэмэгдэж, үерийн хэмжээнд хүрсэн. Тухайлбал, Орхон, Сэлэнгэ, Ховд, Туул, Хараа, Ерөө зэрэг томоохон гол, мөрний түвшин нэмэгдлээ. Тиймээс иргэдийг хөдөө, орон нутагт аялал зугаалганд явахдаа голын уснаас хол байхыг анхааруулж байна. Тэр дундаа бага насны хүүхдийг хараа хяналтгүй голд ойртуулахгүй байх, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ голын усанд орохгүй байхыг иргэд анхаарах хэрэгтэй.

-Баяр наадмын өдрүүдэд иргэд голд осолдсон гэх дуудлага нийслэл болон хөдөө орон нутгийн Онцгой байдлын газарт ирсэн гэж байсан. Ер нь улсын хэмжээнд үер, устай холбоотой хэчнээн дуудлага ирсэн бэ?

-Нийт нутгийг хамран үргэлжлэн орсон борооны улмаас хөдөө орон нутаг дахь Онцгой байдлын газруудад "усанд автсан, үерт нэрвэгдсэн" гэх дуудлага олон ирсэн. Онцгой байдлын алба хаагчид дуудлагын дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллалаа. Ер нь Улаанбаатар, Баянхонгор Дорноговь, Дундговь, Архангай, Өмнөговь, Хэнтий, Төв аймгийн нутгаар бороо орсон. Тухайлбал, Баянхонгор аймгийн Баянхонгор сумын нутаг дэвсгэрт долдугаар сарын 12-13-нд усархаг бороо орсон. Борооны улмаас тус аймгийн Жаргалантын ам гэдэг газраас Шар бууцын ам хүртэлх 10 орчим км газарт үерийн ус бууж, авто машин явах боломжгүй болсон. Мөн Дорноговь аймгийн Айраг сумын дөрөвдүгээр багийн нэг иргэний таван ханатай гэр, байшин усанд автсан гэх дуудлага ирсэн. Завхан аймгийн Цэцэн уул суманд долдугаар сарын 13-ны өдрийн 14:00-16:00 цагт орсон хүчтэй борооны улмаас үер бууж, сумын төвийн зам усанд автан, туу жалга үүссэн. Мөн ус, шаварт суусан дуудлага их ирсэн. Тодруулбал, Баянхонгор аймгийн Баянхонгор суманд "таван зорчигчтой авто машин суусан" гэх дуудлагын дагуу онцгой байдлын алба хаагчид ажилласан. Өмнөговь аймгийн Ханхонгор суманд "зургаан зорчигчтой суудлын авто машин шаварт суусан" гэх дуудлага хүлээж авсан. Ирсэн дуудлагын дагуу харьяа дүүрэг, аймгийн Онцгой байдлын газрын алба хаагчид шуурхай арга хэмжээ авч ажилласан байгаа. Он гарсаар улсын хэмжээнд 57 хүн усанд осолдож, амиа алдсан. Тодруулбал, 20 хүүхэд, 37 насанд хүрсэн хүн усанд осолдож амиа алдлаа. Ирсэн дуудлагуудыг ажиглаж байхад иргэд өөрсдийн буруутай үйлдлээс болж, өөрийгөө болон бусдыг аюулд оруулсан тохиолдол их байлаа. Үерлэсэн голд орох, согтууруулах ундааны зүйл хэрэглэж, найз нөхөдтэйгөө муудалцан голын усанд орох, эсвэл явж болохгүй газраар явж шаварт суух зэрэг зөрчлийг гаргасан. Манай Онцгой байдлын алба хаагчид шуурхай арга хэмжээ авч, дуудлага бүрт хүрч ажиллан иргэдийг авран туслах ажиллагааг явуулсан. Он гарснаас хойш эрэн хайх, авран туслах ажиллагааг 18 аймгийн 36 суманд 38 удаа, нийслэлийн таван дүүрэгт 18 удаа явуулсан байна.

-Хөдөө орон нутагт айлууд голд их ойрхон буудаг шүү дээ. Үүнээс болж үерт нэрвэгдэх тохиолдол гардаг. Үер, усны амнаас хол буулгах, иргэдийг аюулгүй газарт шилжүүлэх тал дээр ямар ажил хийсэн бэ?

-Ихэнх тохиолдолд үер, усны аман дээр буусан айлууд үерт автаж байна. Мөн урин дулаан цаг ирэхээр малчид зусланд

гардаг. Зусланд гарахдаа зөв, оновчтой газрыг сонгодоггүй. Эрт дээр үеэс малчид газрын өндөр, нам, жалга гуу, дов толгойг харж буудаг байсан. Одоо ямар ч хамаагүй газар л буудаг болж. Үүнээс болж үер, усны аюулд өртөх тохиолдол гарч байгаа. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн Өлгий суманд үер боллоо. Өлгий сум нь өөрөө нам дор газар байрладаг. Тиймээс үерийн ус тогтсон. Бороо 30 минут л орсон. Тэр хугацаанд хөндий газрыг үерийн ус дүүргэсэн байгаа юм. Манай Улаанбаатар хотод ч гэсэн нам дор байрласан газрууд олон бий. Бага зэрэг бороо орохоор л ус дүүрээд ороод ирдэг. Тэгэхээр иргэд, тэр дундаа малчид зусланд гарахдаа буух газраа зөв сонгох хэрэгтэй. Үерийн аюул ямар хүнд, аймшигтай болохыг бид бүгд харж байна шүү дээ. Иргэд үүнд ухамсартай хандаж, голын усанд хамаагүй орохгүй байх хэрэгтэй.

-Усны түвшин нь нэмэгдсэн голуудад аюулгүйн зурвас хийсэн үү?

-Манай байгууллага авран туслах үйл ажиллагаа явуулдаг. Усны түвшин нэмэгдсэн гол бүрт аюулгүйн зурвас хийх боломж, бололцоо байхгүй. Ернурьдчилан сэргийлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн Онцгой байдлын газрууд хийдэг. Томоохон гол, мөрөнгөтэй аймгуудад завьт эрүүл гарч ажилладаг юм. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг олон хийж байгаа боловч иргэдийн хариуцлага ухамсар маш муу байдаг. Хэлж, анхааруулахад байхад үерлэсэн гол руу ордог. Үүнээс болж амь наснаа алдсан тохиолдол их байна. Усны ослын дуудлага наадмын өдрүүдэд их байлаа. Бороо нийт нутгаар цаашид үргэлжлэн орно. Тийм учраас иргэд голын усанд орохдоо анхаарал болгоомжтой байх, үерлэсэн голд орохгүй байхыг анхааруулж байна.

-Баян-Өлгий аймгийн Өлгий суманд болсон үер яг хэдэн цагийн үед болсон бэ. Тус аймаг дахь танай салбар ангид хэдэн цагт дуудлага ирсэн бэ?

-Өлгий суманд долдугаар сарын 10-ны өдрийн 16:50 цагт үерийн аадар бороо 30 минут үргэлжлэн орсны улмаас тус сумын нэг, зургаа, ес, 11 дүгээр багийн айл орхүүд үерт нэрвэгдсэн. Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын алба хаагчид,

орон нутгийн 40 иргэн, зургаан автомашин, нэг ковштойгоор 18:52 цагт үерийн голомтод ажиллаж эхэлсэн. Эхний цагийн байдлаар байшингийн нурангид нэг хүн дарагдсан, 18 байшин нурж, 110 орон байр, эд хөрөнгө усанд автсан, голын усанд нэг хүн боогдсон байсан. Мөн гурван хүн дарагдсан гэх мэдээлэл аймгийн Онцгой байдлын газарт ирсэн. Мэдээллийн дагуу гурван хүний амийг аварч, эмнэлэгт хүргэсэн. Усанд боогдсон 154 хүнийг аюулгүй газарт шилжүүлсэн. Голын усанд боогдсон нэг гэрийн таван иргэнийг завиар аюулгүй газарт гаргаж, иргэдийн эд хөрөнгийг авран хамгаалах ажиллагааг явуулаа. Түүнчлэн хүчтэй борооны улмаас дөрвөн настай хүүхэд ус тогтсон нүхэнд унаж, амь эрстсэн байсныг гарган Цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгсөн. Үер нэрвэгдсэн хүмүүст 70 ширхэгт гэр, 14 мянган ширхэг цэвэр ус, махан нөөц, 3.5 тонн гурил, будаа, 700 кг цай, давс, 1400 кг элсэн чихэрийг тусламжаар хүргэсэн. Үерийн дараа ариутгал, халдваргүйжүүлэлт хийх ёстой. Тиймээс ариутгалын хлорын шохой 200 кг, хлорамин 90 кг-ыг тус тус эхний удаа хүргүүлээд байна.

-Ирэх наймдугаар сард цаг агаарын байдал ямар байх вэ. Бороо үргэлжлэн орох уу. Энэ талаар танайд Ус, цаг уурын хүрээлэнгээс мэдээлэл өгсөн үү?

-Ер нь цаашид бороо үргэлжлэн орох төлөвтэй байна. Энэ сарын 18-19-нд нутгийн хойд хэсгээр, 20-нд баруун болон төвийн аймгуудын зарим газраар, 21-нд баруун, төв, говийн аймгуудын нутгаар түр зуурын дуу цахилгаантай бороо орно. Борооны өмнө салхи түр зуур ширүүснэ. Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар шөнөдөө 8-13 градус, өдөртөө 21-26 градус, Их нууруудын хотгор болон говийн бүсийн нутгаар шөнөдөө 15-20 градус, өдөртөө 27-32 градус, бусад нутгаар шөнөдөө 11-16 градус, өдөртөө 24-29 градус дулаан байна. Хугацааны сүүлчээр нутгийн хойд хэсгээр бага зэрэг сэрүүснэ. Ойрын өдрүүдэд бороо, хур ихтэй байх тул иргэдийг хөдөө аялал зугаалганд явахдаа голын усанд орохгүй байхыг анхааруулж байна.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

ХӨВСГӨЛ АЙМАГТ ТАРВАГАН ТАХАЛ ГАРЧЭЭ

Хөвсгөл, Баян-Өлгий аймагт тарваган тахал өвчний шинж тэмдэг илэрчээ. Тиймээс хөдөө орон нутагт руу аялал зугаалгаар явж буй иргэдийг тарваган тахлын голомттой газраас мах идэхгүй байхыг анхааруулж байна. Тарваган тахал өвчин нь нянгаар үүсгэгддэг байгалийн голомтот, цочмог халдварт өвчин юм. Манай орны 17 аймгийн 137 суманд тарваган тахал гарах эрсдэлтэй байгаа ажээ. Иймд улсын хэмжээнд энэхүү тахлын эсрэг дархлаажуулалтын вакциныг энэ сарын 18-28-ны хооронд хийхээр болсон байна.

БНХАУ-ын Ерөнхий сайдын гэргий монгол хүүхдүүдийг баярлуулав

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хүүхэд, залуучуудын сургалт, хүмүүжлийн тусгай цогцолборт суралцдаг хагас болон бүтэн өнчин, эмзэг бүлгийн 165 хүүхдэд БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайдын гэргий, хатагтай Чэн Хун буцалтгүй тусламж үзүүлж, 28 хүний суудалтай хүүхдийн автобус болон компьютер, хувилал машин, цүнх, тоглоом зэрэг нэг сая юанийн хөрөнгө оруулалттай эд зүйлийг хандивлаж, баярлууллаа. Энэхүү хандив тусламжийн барааг гардуулах ёслолын ажиллагаа өнгөрсөн бямба гарагт тус цогцолборт болсон юм.

Тусламжийн барааг гардан авах гэрээнд тус төвийн дарга Б.Лхамсүрэн болон БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Син Хайминь нар гарын үсэг зурав. Ёслолын ажиллагаанд урилгаар БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Син Хайминь болон Бээжинд суугаа Монголын Элчин сайд Ц.Сүхбаатар, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нар оролцож, үг хэлсэн юм. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хүүхэд, залуучуудын сургалт, хүмүүжлийн тусгай цогцолборын захирал Б.Лхамсүрэн "Манай төвд нийслэлийн эмзэг бүлгийн, төрөөс зайлшгүй анхаарах шаардлагатай 4-21 насны хүүхдүүд хамрагддаг. Одоогоор хүүхдийн, залуучуудын гэсэн хоёр бүтэн болон хагас өнчин 165 хүүхэд сурч хүмүүжиж байна. Улаанбаатар хотын есөн дүүргийн захирамжаар хүлээн авч, 18 нас хүртэл нь байрлуулж, хүмүүжүүлж, нийгэмшүүлэх 24 цагийн үйл ажиллагаа явуулдаг" хэмээсэн. Тус цогцолбор нийт 65 багштайгаар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд зуслан болон гадуур үзвэр үзэхэд олон хүүхдийг зөөвөрлөхөд асуудал тулгардаг талаар хэлж байсан юм. Харин одоо хүүхдүүдийн аюулгүй байдлыг хамгаалсан шинэ автобустай болсондоо тэд маш их талархаж байгаагаа хэлж байсан. Мөн гадаадын их дээд сургуулиудад тус цогцолборын сурагчид суралцдаг гэнэ.

Тодруулбал, БНХАУ-ын Бээжин, Нанжины их сургуулиудад дөрвөн оюутан, ӨМӨЗО-ны Шиллийн голын ажил мэргэжлийн дээд сургуулийн мэргэжлийн сургалтад зургаан оюутан, Япон Улсын Нисэхийн академын хөгжмийн сургуульд таван сурагч суралцаж байгаа ажээ. Ёслолын үйл ажиллагааны үеэр БНХАУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд Шин Хайминь, "Манай хоёр орон эртний сайхан найрсаг харилцаатай. Энэхүү найрсаг харилцааны нэгэн илэрхийлэл бол өнөөдөр та бүхэнд БНХАУ-ын Ерөнхий сайдын гэргий Ченг Хонгос ирүүлж байгаа энэ тусламж юм. Би та бүхэнд эрхэмсэг хатагтай Ченг Хонгийн чин сэтгэлийн бэлгийг гардуулж өгөх гэж байгаадаа баяртай байна. Та бүхэнд сурлагын их амжилт хүсье" гэсэн юм.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН



Монголын ирээдүй болсон хүүхэд, залууст өв уламжлалаараа бахархах ухамсарыг төлөвшүүлэх, таниулах, дэлхийн нийтэд Монгол үндэсний хувцасны чалин загварыг гайхуулах зорилго бүхий "Дээлтэй Монгол-2016" наадам боллоо. Эдүгээгээс 10 жилийн өмнө анх зохион байгуулагдаж байсан энэхүү наадамд 100 гаруй хүн оролцож байсан бол энэ жил нийслэлийн есөн дүүрэг, "АПУ", "G Mobile" колтани, ӨМӨЗО-ны төлөөлөгч тэргүүтэй 10 мянга гаруй дээлтэй монголчууд Чингисийн талбайд жагслаа.

Өнөөдрөөс хуучин журмаар замын хөдөлгөөнд оролцоно

Ази, Европын дээд түвшний 11 дугаар уулзалт болж буйтай холбогдуулан замын хөдөлгөөний хэт ачааллаас урьдчилан сэргийлэх зорилгоор долдугаар сарын 16-нд сондгой тоогоор төгссөн, долдугаар сарын 17-нд тэгш тоогоор төгссөн тээврийн хэрэгслийг авто замын хөдөлгөөнд оролцуулсан билээ. Тэгвэл өнөөдрөөс эхлэн хуучин

журмаараа хөдөлгөөнд оролцох гэнэ. Харин зарим орны төрийн тэргүүн, зочид төлөөлөгчдийн албан ёсны айлчлал үргэлжилж байгаа учраас тодорхой чиглэлд хязгаарлалт хийх гэнэ. Иймд замын цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг хүлээн авч, замын хөдөлгөөндөө соёлтой оролцохыг цагдаагийн байгууллагаас уриаллаа.

Худалдааны төвүүд өнөөдрөөс ажиллана

Үндэсний их баяр наадам, АСЕМ-ын дээд хэмжээний чуулга уулзалт болж буйтай холбогдуулан томоохон худалдааны төв болон захуудыг амрасан билээ. Тэгвэл өнөөдрөөс эхдэн зарим худалдааны төвүүд үйл ажиллагаагаа явуулж эхлэх гэнэ. Тодруулбал, "Хүчит шонхор" худалдааны төв, "Хархорин худалдааны төв" өнөөдрөөс эхлэн ердийн цагийн хуваарийн дагуу ажиллана. Харин "Нарантуул" худалдааны төв энэ сарын 20-нд буюу ирэх лхагва гарагт ажиллахаар болжээ.

Туул голд живж байсан иргэдийг аварчээ

Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Харгана амралтын газрын дэргэд Туул голд хүн живж байна гэсэн дуудлагын дагуу Нийслэлийн Аврахангийн албан хаагчид, нэг моторт завьтай бүлэг бүлэг шуурхай аврах ажиллагаа зохион байгуулж, усанд живж байсан иргэний амь насыг авран хамгаалсан байна. Мөн тус дүүргийн 85-р сургуулийн

дэргэд туул голд хүн живж байна гэсэн дуудлагыг 19:05 цагт хүлээн авч Нийслэлийн Аврахангийн албан хаагчид, нэг моторт завьтай бүлэг 19:06 цагт газар дээр очиход Л, Х нар усанд живж байсныг гаргаж эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэн ар гэрийн хүмүүст нь хүлээлгэн өгсөн байна.

МОНГОЛ НААДАМ

ДАРАА ЖИЛИЙН НААДАМ ДААНЧ ХОЛ БАЙНА ДАА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Э.МӨНХ

Тулгар төрийн 2225, Их Монгол Улсын 810, Ардын хувьсгалын 95 жилийн ойн баяр наадам ёстой л нэг дэнж хотойлгож, дэлхийг баясгасан сайхан болж өндөрлөв. Төрийн их баяр наадам нээлтээсээ эхлээд л монгол хүн бүрийг огшуулж, омогшуулж чадсан гэж хэлэхэд болно. Монгол Улсын түүхийг үечлэн үзүүлсэн үзүүштэй сайхан энэхүү ёслолыг Төрийн соёрхолт, УДЭТ-ын Ерөнхий найруулагч Н.Наранбаатар найруулсан бөгөөд түүний найруулгад наадамчин олон бүгд сэтгэл хангалуун байсан юм. Мөн энэ жил Ц.Элбэгдоржийн хувьд Ерөнхийлөгчийн индрээс наадмыг нээх сүүлийн үгээ хэлэх мөч байснаараа онцлогтой. Тиймээс ч тэрбээр “Монгол түмнийхээ цэнгэлийн манлай үндэснийхээ их баяр наадмыг би энэ жил найм дахь удаагаа нээж байна. Найман хүү түрүүлж өсгөсөн малчин ээж аавын эгэл хүүгийн хувьд би энэ их бэлгэшээл хүндэтгэлд сүслэж, монгол түмнийхээ их буян заяа, босоо хийморьт үеийн үедээ залбирч явах болно” хэмээгээд Төрийн есөн хөлт цагаан туганд хүндэтгэл үзүүлэн дэвсэн нь наадамчин олны анхаарлыг татсан юм. Гараа сайн бол бариа сайн гэдэгчлэн наадмын нээлт монгол хүн бүрт таалагдсан болохоор энэ жилийн наадам аандаа л өнгөлөг, гэгээлэг бас ч гэж ярих зүйл ихтэй болсон.

Дөрвөн тэгш ой тохиосон энэ жилийн наадам Улсын даян аварга Г.Өсөхбаяраар тэргүүлүүлсэн улс, аймгийн алдар цолтой хүчит 1024 бөх барилдсанаас Архангай аймгийн Хашаат сумын харьяат, Улсын заан Ч.Санжаадамба уран мэхийг уралдуулан хийж, ид хавыг гайхуулан арав даван, төрийнхөө их баяр наадамд анх удаа түрүүлж, Улсын аварга цолны болзол хангасан бол Архангай аймгийн Булган сумын харьяат, Улсын начин Р.Пүрэвдагва адтой, одтой барилдаж, ес даван үзүүрлэж, Улсын арслан цолны болзол хангасан юм. Энэ жилийн үндэсний их баяр наадамд арын сайхан хангай нутгийнхан одтой сайхан

наадаж, улсын аварга, арслан, начин цолтнуудаа өлгийдөн авсан. Тэгш ой тохиосон үндэсний их баяр наадмын их шөвөгт Сэлэнгэ аймгийн Мандал сумын харьяат Улсын аварга Г.Эрхэмбаяр, Увс аймгийн Ховд сумын харьяат Улсын арслан Н.Батсуурь нар төрийнхөө их баяр наадамд найм даван шөвгөрсөн билээ. Түүнчлэн энэ жилийн наадамар шинээр 14 начин, зургаан харцага, хоёр заан, нэг арслан цолтон төрж, бөх сонирхогчид, бөхөд хайртай монгол түмнээ баярлууллаа.

Морьтон монголчуудын мөнхийн омогшил болсон хурдан морьдын уралдаан ч сайхан болж, уясан эзэн, унасан хүүхдээ баярлууллаа. Тодруулбал, азарганы уралдаанд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын харьяат Т.Болдбаатарын хурдан халиун түрүүлж, аман хүүзүнд Төв аймгийн Баянцагаан сумын уяач Д.Баянбатын наран хонгор хурдалсан юм. Харин айргийн гуравт Завхан аймгийн Яруу сумын харьяат улсын тод манлай уяач Д.Дагвадоржийн Шөвгөр зээрд, дөрөвт Завхан аймгийн Яруу сумын харьяат улсын тод манлай уяач Д.Дагвадоржийн буган халтар хурдалсан бол Хөвсгөл аймгийн Их-Уул сумын харьяат аймгийн алдарт уяач Д.Энхтөрийн хул хурдалж, наадамчин олноо баясгалаа. Их насанд Өвөрхангай аймгийн Тарат сумын харьяат Б.Энхбаатарын хонгор түрүүлж, Завхан аймгийн Дөрвөлжин сумын харьяат Д.Баяраагийн хурдан хүрэн аман хүүзүнд хурдалсан. Айргийн гуравт Төв аймгийн Эрдэнэцогт сумын харьяат Хакухо М.Даваажаргалын хүрэн зээрд, дөрөвт Төв аймгийн Сэргэлэн сумын харьяат Ц.Хэнмэдэхийн дэлтэй хонгор, тавд Завхан аймгийн Идэр сумын харьяат Н.Мөнхбаясгалангийн зээрд давхиж, унасан хүүхэд, уясан эзэнээ баярлуулсан. Монгол түмний тоосонд нь ороход бүтэн жилийн хийморь сэргэдэг хэмээн бэлгэшээдэг соёлоон насны морьдын уралдаанд Монгол орны дөрвөн зүг, найман зовхисоос ирсэн 295 хурдан буян бүртгүүлж, худалснаас Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Д.Дагвадоржийн хурдан бор үрээ түрүү магнайнд ирж, Архангай аймгийн

харьяат Ө.Пүрэвбаатарын хурдан загал үрээ аман хүүзүдсэн. Харин айргийн гуравт Төв аймгийн Алтанбулаг сумын уяач С.Дамбажавын хурдан хээр үрээ, дөрөвт Төв аймгийн Алтанбулаг сумын уяач Д.Ганзоригийн хонгор халзан үрээ, тавд Говь-Алтай аймгийн Бигэр сумын харьяат Л.Батмөнхийн үрээ хурдлав. Хязгаалан насны морьдын уралдааны түрүү магнайгаар Дундговь аймгийн Хулд сумын Б.Лхагва-Очирын хүрэн үрээ хурдалсан бол Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Т.Галбадрахын бор үрээ аман хүүзүнд давхиж. Айргийн гуравт Дорноговь аймгийн Хулд сумын Н.Батжаргалын шарга үрээ, дөрөвт Ц.Энхтайваны хонгор үрээ, тавд Ж.Мөнхсүрэнгийн бор үрээ орж ирсэн юм. Шүдэн насны морьдын уралдаанд Архангай аймаг Их тамир сум Ж.Уясахын бор үрээ түрүүлж, Увс аймгийн Малчин сумын уяач Ц.Нүүдийн хонгор үрээ удаалсан. Харин айргийн гуравт Өмнөговь аймгийн Цогтцэцэдий сумын уяач Х.Түмэнбаярын хурдан буурал, дөрөвт Ховд аймгийн Алтай сумын Ц.Гантөмөрийн хонгор үрээ, тавд Баянхонгор аймгийн Богд сумын Д.Ганболдын хар үрээ хурдаллаа. Наадамчин түмний хамгийн их өхөөрдөн үздэг хурдан дагааны уралдааны түрүү магнайд Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын уяач Д.Аюулхүүгийн хурдан халиун даага ирсэн бол Ховд аймгийн цэцэг сумын харьяат Н.Баасанжавын хээр даага аман хүүзүнд хурдалсан юм. Харин айргийн гуравт Төв аймгийн Архуст сумын уяач Н.Лхагвадоржийн зээрд даага, дөрөвт Дундговь аймгийн Адаацаг сумын Н.Цэндийн зээрд халзан даага, айргийн тавд Сод манлай уяач н.Бат-Эрдэнийн бор халзан даага давхисан. Харин энэ жилийн “баян ходоод”-оор Өвөрхангай аймгийн Төгрөг сумын уяач н.Нохойцагааны зээрд даага тодорсон юм. Энэ жилийн баян ходоод ирэх жилийн түрүү магнай болох болтугай гэсэн ерөөлийг наадамчин түмэн хэлж байлаа.

Эрийн гурван наадмын нэг сурын харваа энэ жил улсын мэргэн цолтнуудаар эгнээгээ тэлсэн.

Завхан аймгийн Эрдэнэбулган сумын уугуул Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн эрчим хүчний цехийн засварчин, Хангарьд спортын хорооны тамирчин Монгол Улсын спортын мастер Д.Дэмбэрэлсайхан, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын уугуул Нийслэлийн 52 дугаар сургуулийн харваач Монгол Улсын спортын мастер Б.Пунсалдулам нар Монгол Улсын Мэргэн цолны болзол хангаж, Ерөнхийлөгчөөс Мэргэн цолны тэмдэг үнэмлэх, Үндэсний их баяр наадмын түрүү харваачийн медалиа гардаж авсан юм. Харин хүүхдийн харваанд хөвгүүдээс Баян-Өлгий аймгийн Алтай сумын уугуул ШШГЕГ-ын Сүлд спорт хорооны харваач, Өсөх идэр мэргэн Н.Алтантулга, охидоос Дорноговь аймгийн Хантанбулаг сумын уугуул ерөнхий боловсролын V сургуулийн 11 дүгээр ангийн сурагч С.Цэдэг-Өлзий төрийнхөө их баяр наадамд түрүүлж, Ерөнхийлөгчөөс шагналаа гардан авсан. Үндэсний их баяр наадмын шагайн харваанд 72 багийн 720 харваач цөц мөргэнээ сорин оролцож, Монгол Улсын үлэмж дархан мэргэн Л.Түвшинжаргал ахлагчтай баг түрүүлсэн. Ийнхүү Тулгар төрийн 2225, Их Монгол Улсын 810, Ардын хувьсгалын 95 жилийн ой, монгол түмний их баяр цэнгэл наадам сайхан болж өндөрлөв. Хүн бүхэн энэ жилийн наадам өнгөтэй, сайхан болсныг одоо ч шагшин магтсаар байна. “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд ч олон сайхан урлагийн тоглолт болсон нь энэ наадмын бас нэгэн чимэг боллоо. Энэ бүхнийг зохион байгуулж, ингэж сайхан наадуулсан хүмүүст талархах нь зүйн хэрэг биз ээ.

